

[Type here]



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 06-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-36

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	6 8-34
2.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн/	7 34-36

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 06-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 70 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн, С.Ганбаатар, Ц.Мөнхбат,
Л.Мөнхбаясгалан, Б.Түвшин, А.Ундраа, О.Цогтгэрэл, Д.Энхтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, С.Лүндэг, Г.Очирбат, Б.Тулга;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Х.Булгантуяа,
М.Нарантуяа-Нара, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Б.Уянга, Ж.Энхбаяр;
Тасалсан: Х.Баттулга;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-3 цаг 56 минут, Б.Бадамсүрэн-13 минут,
Б.Батбаатар-09 минут, Д.Батбаяр-26 минут, Б.Батцэцэг-13 минут,
Э.Батшугар-5 цаг 24 минут, Б.Баярбаатар-03 минут, Э.Болормаа-1 цаг 13 минут,
С.Бямбацогт-01 минут, Г.Ганбаатар-3 цаг 57 минут, Д.Ганбат-1 цаг 01 минут,
Д.Ганмаа-13 минут, Х.Ганхуяг-6 цаг 34 минут, Ц.Даваасүрэн-10 минут,
Т.Доржханд-4 цаг 00 минут, Х.Жангабыл-12 минут, Б.Жаргалан-1 цаг 16 минут,
Б.Заяабал-12 минут, Ж.Золжаргал-03 минут, Т.Мөнхсайхан-5 цаг 02 минут,
П.Мөнхтулга-5 цаг 37 минут, Б.Найдалаа-06 минут, Н.Наранбаатар-4 цаг 25 минут,
О.Номинчимэг-16 минут, Б.Пунсалмаа-14 минут, Ц.Туваан-6 цаг 31 минут,
Ч.Ундрал-6 цаг 16 минут, Н.Учрал-6 цаг 11 минут, Г.Хосбаяр-05 минут,
Д.Цогтбаатар-36 минут, Ж.Чинбүрэн-38 минут, Б.Чойжилсүрэн-17 минут,
Р.Эрдэнэбүрэн-1 цаг 49 минут.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт
өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний
өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсжаргал, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нийслэлийн өмчит “Улаанбаатар түншлэл төв”-ХХК-ийн захирал З.Батырбек, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Цэрэнсамбуу, мөн компанийн Геологи, уул уурхайн төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Хишигбаатар нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаанаас завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./10:08/

Хоёр. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаанаас завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./10:10/

Үдээс өмнөх хуралдаан 06 минут үргэлжилж, 10 цаг 10 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 00 минутад эхлэв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Ж.Алдаржавхлан завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 1 цаг 30 минутын завсарлага өгөв./14:01/

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу үг хэлэв.

Хуралдаан 14 цаг 02 минутад завсарлаж, 16 цаг 05 минутад үргэлжлэв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн/-ийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийн явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Ө.Шижир, Д.Пүрэвдаваа, Ж.Батсуурь, Б.Мөнхсоёл, С.Цэнгүүн, М.Мандхай, Ц.Сандаг-Очир, О.Саранчулуун, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Сангийн сайд Б.Жавхлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсжаргал нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /17:45/

Уг асуудлыг 17 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа байлцав.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж уг асуудлыг түр хойшлуулав. /17:50/

Уг асуудлыг 17 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 53 минут үргэлжилж, 126 гишүүнээс 105 гишүүн хүрэлцэн ирж, 83.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

**2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 04 минут**

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Ирц 126 гишүүнээс 70 гишүүн ирж, 55.6 хувиар өнөөдрийн чуулганы хуралдааны ирц бүрдсэн байна.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 2 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт нь Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Засгийн газар 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Хоёрдугаарт нь “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025 оны 10 сарын 6-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх асуудалтай холбоотой санал ирээгүй байгаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Засгийн газар 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Энэ хуультай холбоотойгоор Ардчилсан намын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал үг хэлнэ. Монгол Ардын намын.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монгол Улсын 2026 оны төсвийг дагуулж өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүд дээр Монгол Ардын нам дахин бас ярилцах асуудал байгаа тул завсарлага авч байна. Үдээс өмнө. Үдээс өмнө.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ер нь энэ төсөв, мөнгөний бодлого маш чухал. Тийм учраас энэ төсвөө цаг хугацаандаа батлах асуудал маш чухал байгаа. Тэгэхээр ер нь олон улсын Эс Эн Пи гээд үнэлгээний байгууллагаас манай зээлжих зэрэглэлийг “В” болгож нэмэгдүүлсэн байгаа. Энэ 2012 оноос хойш анх удаагаа 14 жилийн, 13 жилийн дараа энэ буцаж энэ ийм өндөр үнэлгээ дээр очиж байгаа анхны тохиолдол болж байгаа.

Тэгэхээр энэ олон улсын хөрөнгө оруулагчдын итгэлийг маш их татдаг, дээрээс нь хардаг ийм үнэлгээ байгаа. Moody's ч гэсэн бас өнгөрсөн сард бас тодорхой хэмжээгээр М2-ээс В1-рүү шилжүүлсэн байна. Тэгэхээр ер нь энэ төсөв, мөнгөний бодлого дээр их хариуцлагатай ажиллаж энэ ирэх оныхоо энэ эдийн засгийн чухал үзүүлэлтүүдийг маш хурдан шуурхай шийдэх нь Ардын намын хувьд маш их чухал байна. Саяхан хүртэл Трамп Ерөнхийлөгч Холбооны нөөцийн банкны захирал Жеромыг дуудаад ингээд 250 мянган ажлын байрыг бий болгохын тулд 2 функтээр бодлогын хүүг буулга гэсэн.

Гэтэл Жером Пауэлл та 250 мянган хүний эрх ашгийг, ажлын байрны асуудал ярьж байгаа би 300 сая хүний амьдралын асуудлыг шийднэ гэж хэлээд гараад явж байх жишээтэй. Тийм учраас энэ төсөв мөнгөний бодлого чинь маш чухал шүү. Энэ та бүхэн энэ цаг хугацаандаа үдээс өмнө энэ асуудлаа хэлэлцээд үдээс хойш бид нар энэ асуудлаа ярихгүй бол 15-ны дотор төсвөө баталж чадахгүй шүү гэдгийг хэлье. Хэлэлцэх асуудал 2.

14 цаг хүртэл завсарлага өглөө.

Хэлэлцэх асуудал 2. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Буяагийн Тулга танилцуулна. Индэрт урьж байна.

Энэ тогтоолын төсөлтэй холбоотойгоор Монгол Ардын намын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал үг хэлнэ.

Ж.Батжаргал: Манай бүлэг үдээс өмнө завсарлага авч байгаа. Тийм учраас энэ асуудал дээр ч гэсэн бас ярилцаад орж ирье. Ойлгож байна. Улс орны амьдрал ахуйг зохицуулж байгаа энэ улсын төсвийг нэлээн нягт тооцоолол, судалгаануудаа харж нэлээн бодитой батлах ёстой. Тийм учраас энэ дагасан хууль тогтоомжууд дээрээ эргэж бас ярилцах зүйлүүд байгаад байгаа юм. Тийм учраас завсарлага авч байгаа. Таны хэлж байгааг ойлгож байна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 14 цаг хүртэл завсарлага өгье.

Үдээс өмнөх чуулган Монгол Ардын намын бүлэг завсарлага авсантай холбоотойгоор түр завсарлаж байна.

10.10 цаг

Пүрэв гараг 06 Арваннэгдүгээр сар 2025

Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 00 минут

**ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН
ХУРАЛДААН**

Б.Пүрэвдорж: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан эхэлж байна. Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Алдаржавхлан үг хэлнэ.

Ж.Алдаржавхлан: Их Хурлын дэд даргад баярлалаа. Монгол Ардын намын бүлэг одоо хуралдаж байгаа. 2026 оны төсөв болон түүний дагалдаж орж ирсэн хуулиудын төсөл, мөн бусад асуудлаар өнөөдөр хэлэлцэж байгаа, бусад асуудлаар байр сууриа нэгтгэх шаардлагатай байгаа учраас өнөөдрийн хуралдаанаас завсарлага авч байна. Завсарлага авч байна Их Хурлын дарга аа.

Б.Пүрэвдорж: Ардчилсан намын бүлгийн дэд дарга Лодойсамбуу үг хэлнэ.

Ч.Лодойсамбуу: Төрийн ажлыг гялс явуулъя. Ардын намынхан. Юун байр сууриа нэгтгэх вэ, яасан нэгтгэж ханадаггүй юм бэ? Юун дээр нэгтгэх гэсэн юм? Одоо ингээд Засгийн газар нь тогтож үлдэхийн тулд Их Хурлыг авилгаддаг. Тэр авилгаа явуулах уу, байх уу гэдгээ ярилцдаг. Энэ Монголчууд энийг харж байна шүү дээ. Хэд завсарлага авах гэсэн юм. Одоо ажлаа явуулъя Пүүжээ даргаа.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 12.1-д завсарлага авах хугацаа 5 өдөр байлаа гэхэд 3 өдрөөр сунгадаг. Түүнтэй адилхан энэ агуулга өөрөө энэ 12.1-д заагдсан учраас та бүхэн 10 цагаас 1 цаг хүртэл 3 цагийн завсарлага авсан. Тийм учраас 1 цаг 30 минутын завсарлага өглөө. 15:30 хүртэл завсарлага өглөө.

Б.Пүрэвдорж: Үдээс хойших Монгол Ардын намын авсан завсарлага дууссан байгаа. Үдээс хойших чуулганы хуралдаан эхэлж байна.

Манай Ардчилсан намын бүлгийн болон ХҮН нам болон бусад намууд чуулганы хуралдаандаа ирсэн байна. Монгол Ардын намын бүлэг орж ирэхгүй байна. Чуулганы хуралдааны завсарлага авсан дууссан.

Хэлэлцэх асуудал нэгд орёё. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг.

Засгийн газар 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг. Асуулт, хариулт 90 минутын турш үргэлжилнэ. Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгийг уриарай.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг 2025 оны 11 сарын 6-ны өдрийн 14 цаг хүртэл завсарлага авсан. Мөн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн хүсэлтээр завсарлагын хугацааг 2025 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр 15 цаг 30 минут хүртэл сунгасан бөгөөд завсарлагын хугацаа дууссан байна.

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Монгол Ардын намын бүлгийн даргаас үг хэлэх эсэхийг асуух байсан. Байхгүй байна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 10 дугаар сарын 17, 24-ний өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-д заасны дагуу Эдийн засгийн байнгын хороо Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хийж, хууль, тогтоолын төслийг зүйл тус бүрээр хэлэлцлээ.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 22, 23 дугаар тогтоолоор Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж ажилласан бөгөөд тус ажлын хэсгээс багш, эмч, эмнэлгийн ажилчдын цалин, ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлж байгаатай холбогдуулан татварын зардлыг бууруулах зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжих хугацааг хойшлуулж, хуулийг 2026 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх, “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, орд ашиглалтыг сайжруулахдаа хөрөнгө оруулагчийг нээлттэй сонгон шалгаруулах, бүтээгдэхүүний арилжааг хуулийн хүрээнд нээлттэй, ил тод, үр ашигтай зохион байгуулах зарчмын асуудлыг төсөлд тусгах саналуудыг бэлтгэн хэлэлцүүллээ.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.14-д заасан хугацаанд ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэж томьёолон та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийн нэрийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд. Энэ 2 хариулт өгөх хүмүүс сайд нараа дуудаарай. Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сэрээнэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Төмөрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүү, бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалт оруулалтын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Маамбын Үнэнбат Нийслэлийн Засан даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, З.Батырбек Нийслэлийн өмчит “Улаанбаатар түншлэл төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Монхоогийн Амгаланбаатар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн захирал, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Нүрээдгомбын Цэрэнсамбуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч. Энэ олон жилийн энэ нүүрсний хулгайтай асуудал дээр хамгийн их холбогдсон нөхөр орж ирж байгаа юм байна даа. Та наадах чуулганы танхимыг орхиод гаргачих даа. Танаас асуулт асуухгүй. Ховдбаатарын Хишигбаатар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Геологи, уул уурхайн төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт асууна.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд дээрээс бас нэг асуулт байгаа. Монгол Улс өнөөдрийн байдлаар 5.7 тэрбум ам.долларын нөөцтэй гээд бүртгэгдээд явж байгаа. Сүүлийн үед гарч байгаа олон улсын зээлжих зэрэглэл тогтоодог байгууллагуудаас ч гэсэн бас Монгол Улсыг нэлээн эергээр үнэлж 3-н ч байгууллага үнэлгээг сайжруулсан ийм дүгнэлт гарсан байгаа.

Тэгтэл бид нар Ирээдүйн өв сан дээрээ тодорхой хэмжээний мөнгийг байршуулаад хадгалчихсан байгаа. Хадгалж байгаа хүү нь 3-4 орчим хувийн хүүтэй хадгалагдаж байгаа. Гэтэл өнгөрсөн жил нийслэл бонд гаргасан 8-10 хувийн хүүтэй эх үүсвэр татаж байгаа, Хөгжлийн банк бас эх үүсвэр татаж байна. Бас 8-10 хувийн зардалтайгаар татаж байгаа гэсэн үг.

Гэтэл бид нар яагаад тэр Ирээдүйн өв сан дээр байгаа тэр хямд зардлаар хадгалуулаад байгаа мөнгөө эдийн засгийн эргэлтэд оруулах тал дээр тогтоолын төсөл ч юм уу, хууль ч юм уу санаачлаад ажиллаж болохгүй байгаа вэ? Энийг яаж илүү үр ашигтай ажиллуулах вэ? Жишээлэхэд бид нар Ирээдүйн өв сан дээр хадгалж байсан мөнгөөрөө жишээлэхэд алт худалдаж авсан бол алтны үнэ, ханш 2, 3 дахин өслөө. Жишээлэхэд “Apple” компанийн хувьцааг худалдаж авсан бол бас тодорхой хэмжээнд өсөлт гаргаж, менежмент хийж бид нар хадгалж байгаа мөнгөө зөвхөн хадгаламжийн хүүгээс илүүгээр үр өгөөжийг нь хүртэх боломж байсан. Энэ дээр Монгол Улсын Засгийн газраас ямархуу арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ? Энэ дээр бас мэдээлэл авмаар байна.

Хоёрт нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр тодорхой төслүүдийг хэрэгжүүлээд явахад зарим дээр нь ТЭЗҮ шаардахгүй гэдэг юм яриад байгаа юм. Гэтэл төсвийн хөрөнгө оруулалтаар маш том хэмжээний төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлээд явъя гэхэд дандаа ТЭЗҮ гэдэг юм яригддаг. Энэ дээр энийгээ бас яг тодорхой зааж өгөхгүй бол зарим дээр нь ТЭЗҮ байж болно гэж ийм онгорхой заалттайгаар явж болохгүй. Бүх асуудлууд төр, хувийн хэвшлийн түншлэл гэдэг дээр ТЭЗҮ-гүй гэдэг байдлаар араас нь энэ дээр чинь орж ирэхээрээ дахиад төсвийн хөрөнгө оруулалтаар нөхөж төлөх асуудал яригдах учраас энэ дээр бас тэр ТЭЗҮ-ийг тодорхой зааж өгөх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Энэ дээр бас холбогдох хүмүүсээс нь тайлбар, мэдээлэл өгөөч гэсэн ийм 2 асуулт байна.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн 4 дүгээр индрийн микрофон. Нэрээ хэлээд хариулаарай.

С.Тулга: Тулгаа Сангийн яам, гишүүний асуултад хариулъя. Ирээдүй өв сангийн хүүгийн орлогын хувьд бид нар Төв банкны харилцагч гадаад улсын төв банкнууд 4.1 хувийн хүүтэй мөнгөө байршуулсан байгаа. 4.1 хувь нь болохлоор долларын 4.1 хувь. Ерөнхийдөө энэ Америкийн төв банкны үнэт цаасны хүүтэй ер нь ойролцоо түвшинд ингэж хадгалж байгаа. Яагаад энд хадгалж байгаа вэ гэхлээр Ирээдүйн өв сангийн тухай хууль болон Үндэсний баялгийн сангийн тухай хууль дээр энэ хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ Засгийн газар найдвартай байдал, хөрвөх чадвар энэ 2 нөхцөлийг зэрэг хангасны үндсэн дээр өгөөжийн зохистой түвшинд өгөөж эрсдэлийн зохистой түвшинд удирдана гэсний дагуу ингэж ерөнхийдөө хамгийн найдвартай байдлаар хадгалж байгаа.

Яг одоогийн байдлаар энэ хадгалж байгаа байдал нь эрсдэлийн хамгийн доод түвшин өгөөжийн ерөнхийдөө хамгийн дээд түвшин гэсэн энэ нөхцөлөөр хадгалж байгаа. Засгийн газраас баталсан хөрөнгийн удирдлагын бодлогын хүрээнд бид нар сая гишүүний ярьсан шиг хувьцаанд хөрөнгө оруулж болно. “Apple”-ын хувьцаа ч юм уу, аль эс үгүй бол алт худалдаж авах ч юм уу. Ингэсэн тохиолдолд энэ алтны үнэлгээ буюу хувьцааны үнэлгээ буурсан тохиолдолд Ирээдүй өв сангийн хөрөнгийн үнэлгээ маань дагаад буурна. Жишээлбэл 10 хувиар үнэлгээ нь буурлаа гэхэд 130 сая ам.доллараар Ирээдүй өв сангийн одоогийн байгаа 1.3 тэрбум ам.доллар буурах ийм эрсдэлүүд байгаа учраас хамгийн бага эрсдэлтэй, өндөр өгөөжтэй энэ хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулсан байгаа.

Хөрөнгө оруулалтыг 3 сараас эхэлж хэрэгжүүлсэн. Тэгээд өнөөдрийн байдлаар буюу 11 сарын 6-ны өдрийн байдлаар бид нар хүүгийн орлого 96.1 тэрбум төгрөгийн хүүгийн орлого ерөнхийдөө олчихсон явж байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Өлзийхүүгийн Шижир гишүүн. 2 дахь асуултад хариулах юм байна.

Т.Баясгалан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Баясгалан байна. Тэгэхээр энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн 18.4-д бол энэ хуулийн 5.1.13-д заасан төрийн үйлчилгээ үзүүлэх төслөөс хамааран ТЭЗҮ шаардахгүй бөгөөд мөнгөний үнэ цэний шинжилгээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн шинжилгээ, хууль зүйн дүн шинжилгээ болон нийгмийн нөлөөллийн шинжилгээ хийж болно гэсэн ийм заалт нэмэлтээр орсон байгаа.

Яагаад ийм заалт орж байна вэ гэхээр Түншлэлийн хуульд зааснаар түншлэлийн гэрээний төрлүүд одоогоор 9 төрлийг хуульчилсан. 10-т нь ямар нэгэн бас нээлттэй орхисон бусад гэрээний төрлөөр төслүүдийг хэрэгжүүлж болохыг хуульчилсан байгаа. Тухайлбал бас эмнэлэг, сургуулийн менежментийг түншлэлээр хэрэгжүүлэхэд төрийн үйлчилгээний төслүүд дээр түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд заавал ТЭЗҮ шаардахгүй. Харин бусад дагалдах шинжилгээнүүдийг заавал хийсэн байхыг шаардаж байгаа. Харин нийтийн зориулалттай дэд бүтцийн түншлэлийн төслүүдэд бүгдэд нь ТЭЗҮ хийгдсэн.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Тодруулъя.

Да.Цогтбаатар: Энэ сая Сангийн яамнаас тооцоолол их асуугаагүй. Засгийн газраас дагаж оруулж ирж байгаа хууль, бодлоготой холбоотойгоор асуулт асуугаад байгаа юм. Учрал сайдаас бусад хүн алга байна. Уг нь Сангийн сайд, эсвэл Ерөнхий сайд юм уу ороод ирсэн бол илүү тодорхой хариулах байх гэж бодож байна. Учрал сайд хариулбал энэ дээр бас хариулт өгөх хэрэгтэй байна. Эдийн засгийн яам өөрөө прогноз хийгээд бодлого гаргаад явж байгаа. Эдийн засгийн тооцооллууд дээр. Бид нар жишээлэхэд алтыг унана гэдэг төсөөлөл ойрын үед ерөөсөө харагдахгүй байгаа. Энэ өнгөрсөн 1 жилийн хугацаанд алт тогтмол өсөж ирсэн яг миний мэдэж байгаагаар бол. Гэтэл бид нар одоо болтол энэ хөрөнгө оруулалт, менежментийнхээ компанийг хөдөлгөж чаддаггүй, Засгийн газар дээр ажил хийгдэхгүй байгаад байна. Гэтэл дахиад бид нар Эдийн засгийн хөгжлийн яам гэдэг яамтай. Яам яг юуг нь Засгийн газарт зааж чиглэх юм? Эдийн засгийн хөгжлийн яам яг энэ асуудал дээр.

Энэ төр, хувийн хэвшлийн түншлэл дээр тодорхой нэршлүүдээ өөрчилж явахгүй юм бол 1 дахиад минут.

Да.Цогтбаатар: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Үндэсний баялгийн сангийн 2024 онд батлагдсан хуулиар дотроо 3 сантай. Тэгээд Хөгжлийн санг Эдийн засаг, хөгжлийн яам хариуцдаг. Цаашдаа Хөгжлийн сан өөрөө ямар ямар төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх вэ гэдэг

чиглэлээр жагсаалтыг Их Хурлаар оруулж батлах ийм хууль, эрх зүйн орчинд ажилладаг. Гэхдээ одоо Хөгжлийн сан дээр хуримтлал байхгүй. Мэдээж Цогтбаатар гишүүний хэлж байгаагаар бид нар яг Хөрөнгө оруулалтын сангийн жишгээр хөрөнгө оруулалт менежментийн компаниар удирдуулаад, эрсдэлгүй хөрөнгөд хөрөнгө оруулах, хувьцаа авах, Засгийн газрын бонд үнэт цаас авах чиглэлээр ажиллах эрх зүйн орчин бүрдсэн.

Гэхдээ Үндэсний баялгийн сангийн хуульд бас нэмэлт, өөрчлөлт оруулах, Хөгжлийн санг санхүүжүүлэх зорилготойгоор бас хуулийн төсөл дээр ажиллаж байгаа. Тэгээд удахгүй оруулж ирнэ.

Б.Пүрэвдорж: Цогтбаатар гишүүн нэмж тодруулъя.

Да.Цогтбаатар: Тодруулах гэж одоо бол санал хэлэх гэсэн юм. Төр, хувийн хэвшлийн түншлэл дээр яг тодорхой зааж өгөхгүй бол асуудлуудыг яаж ч мушгиж хэрэглэж болох гээд байгаа юм. Дүгнэлт гаргуулдаг нэртэйгээр. Жишээлэхэд өнгөрсөн жил энэ 2025 онд улсаараа ч харлаа, нийслэлээрээ ч харлаа. Зүв зүгээр байгаа замыг, зүв зүгээр байгаа явган хүний бордюрыг яаж үргүй зарцуулаад 50 хэдэн тэрбум төгрөг зарцуулаад бүгдийг нь сольж болдгийг харууллаа шүү дээ. Дахиад бид нар жишээлэхэд зам зүгээр байхад хуулаад төр, хувийн хэвшлийн түншлэл гэдэг нэртэй үргүй зардал гаргах боломжтой байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр эдгээр дээрээ яг тодорхой зааж өгч оруулаач гэдэг ийм санал хэлээд байгаа юм. Одоо болтол тэр санал нь орж ирэхгүй. Зарим юман дээр жишээлэхэд эмнэлэг, багш нарын үйлчилгээ дээр авна гэхэд энэ өрөөсгөл ойлголт. Эдгээрийг маш сайн засаж янзалж явах ёстой шүү гэж анхааруулж хэлэх гэсэн юм.

Б.Пүрэвдорж: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Төсвөө мартчихсан нь уу Монгол Ардын намынхан л гэж хэлмээр байна. Ажлаа хийе. Эсвэл та нар ажил хаялт зарлаад байгаа юм уу? Нэг бол тэрийгээ ил хэл. Одоо энэ танхимд чинь 68 гишүүнээс 7 Ардын намын Их Хурлын гишүүн байна шүү дээ. Нэг бол энэ ажил хаялтаа албан ёсоор зарладаг юм уу, яадаг юм? Цалингаа нэмье гээд байгаа юм уу? Сая яг энэ дээр сая Улсын Их Хурлын чуулганы танхимд хүүхдүүд танилцаж байна. Ажлаа хийдэггүй юм байна гэдэг ойлголттой буцна шүү дээ энэ ордноос чинь. 9 сарын 1-нд улсын төсөв өргөн барьснаас хойш 76 хонож байна. Түүний 56-д нь та нар хоорондоо ёстой ямбийтал зодолдлоо шүү дээ. Одоо энэ төсвөө хэлэлцье.

Ер нь ингээд 3 дараалаад ялчихаар надад хэн хэлж, нохойг хэн саах юм гэсэн байдалтайгаар ханддаг юм байна. Төрийн дээр нам гарчихсан байдаг юм байна. Намынх нь зовлон төрийн зовлон болдог юм байна. Ер нь дахиж битгий сонгоорой энэ ирэхгүй байгаа хүмүүсийг. Сонгогчид хэлмээр байгаа юм. Тэгээд 2 асуулт байна. 2 асуулт байна.

Эхнийх нь энэ үг, үсгийн алдаа юм уу мэдэхгүй. Төсөв дагасан хууль дээр чинь, танилцуулга дээр экспортыг нэмэгдүүлнэ гээд. Тухайлбал 1 тэрбум долларын 3-5 удаагийн нүүрсний том арилжааг амжилттай зохион байгуулаад эхний дэнчин төлбөр болох 250-300 орчим тэрбум ам.долларыг Монгол Улсад татан төвлөрүүлэх боломжтой гэхихсэн байна. Хөөш энэ хаанаас энэ хэн ийм тоо

бодоод байдаг юм? 250-300 тэрбум доллар татан төвлөрүүлэх боломжтойгоо тайлбарла даа эхнийх нь.

Хоёрдугаарх нь 20 тонн алт ирэх жил олборлоно гээд та нар орлого талдаа төсөөлөөд зардлаа тавьчихсан. Тэгээд Алт-3 хөтөлбөрийнхөө хүрээнд яаж хэрэгжүүлэх юм гэдэг нь бас тодорхойгүй. Энэ 250-300 тэрбум долларын орлого олно гээд энэ өгчихсөн байгаа танилцуулгыг чинь сонсмоор байх юм. Тэгвэл одоо бид нар чинь хөгжлөөрөө бараг Солонгосыг гүйцэх нь байна шүү дээ. Хэдэн жилийн дотор 250-300 тэрбум доллар зөвхөн нүүрснээс олж байгаа бол. Тэгээд энэ 2 асуултад хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Уул уурхайн яам индрийн 4 дүгээр микрофон.

Б.Дашпүрэв: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Дашпүрэв гишүүний асуултад хариулъя. 2026 оны төсөв дээр бид бүхэн 90 сая тонн нүүрс олборлож экспортлох төлөвлөгөөтэй байгаа.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон.

Б.Дашпүрэв: Дашпүрэв. “Бортээг”-тэй холбогдолтой асуудал нийтдээ 2 лицензийн хэмжээнд 1 аравны тэрбум тонны нөөцтэй ийм орд байгаа. Энэний 1 лицензийн хэмжээнд 424 сая тонн нүүрсийг ил уурхайн хэмжээнд олборлолт дээр явуулна. Жилдээ 2-15 сая тонн нүүрсийг олборлох боломжтой гэдэг ийм ТЭЗҮ-гийн тооцоо байгаа.

Б.Пүрэвдорж: Даваахүүгийн Пүрэвдаваа. Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Алт-3 ерөөсөө ярьсангүй. Би асуусан шүү дээ Алт-3-аа яаж хэрэглэх гэж байгаа юм бэ? Та нар 20 тонн алт олборлоно. Монголбанканд тушаана гээд орлогыг нь тооцоолоод 26 онд төсөв дээр тавиад зардлаа биччихсэн.

Хоёрдугаарх нь энэ цаасан дээр чинь урьдчилгаа төлбөрөөр дэнчингийн мөнгөөр 250-300 тэрбум доллар татан төвлөрүүлнэ гээд биччихсэн байна. Энийгээ тайлбарлаадхаач. Алдаа бол алдаа байна гээд энэ дээр хэлчих. Алдаа биш бол ийм тооцоолол байна гээд тооцооллоо ярьчих. Одоо нэг бол сайд нар нь орж ирж хариулмаар байна. Энэ цаасан дээр чинь ингээд биччихсэн байна шүү дээ Учрал сайд. Төсвийн тухай ном дээр чинь гишүүдэд тараасан. Тэгээд тэр 20 тонн алтаа яаж олох юм гэдгээ яриач. Асуугаад байна шүү дээ.

Б.Пүрэвдорж: Уул уурхайн сайдыг дуудаарай, энэ сайдуудаа дуудаарай. Индрийн 4 дүгээр микрофон.

Б.Дашпүрэв: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Дашпүрэв. 20 тонн алтны төлөвлөлт байгаа. Бид бүхэн бүх уурхайнуудынхаа уулын ажлын төлөвлөгөө дээр суурилж тооцоо, судалгаагаа гаргадаг. Энэ бүх үндсэн болон шороон ордын олборлолт хийж байгаа. Мөн шинээр хэрэгжүүлэх төслийнхөө үр дүнгийн тооцоо, ТЭЗҮ, уулын ажлын тайлан, төлөвлөгөө дээрээс нь тусгаж авсан ийм санал

байгаа. Тэгэхээр 20 тонндоо хүргэж ажиллана. Ер нь Алт-3 хөтөлбөртэй холбогдолтой ялангуяа энэ төр захиргааны үйл ажиллагаануудыг хялбарчлах, уулын ажлын тайлан, төлөвлөгөөг богино хугацаанд баталж өгөх, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөхөөр энэ нөөц үүсгэх, нэмэлт хайгуулын ажлыг хийх ийм бодлогын ажлуудыг дэмжиж ажиллаж байгаа.

Б.Пүрэвдорж: Сайд тодруулъя. Шижир гишүүн саяынх асуултаар 300 тэрбумын урьдчилгаа төлбөр гэдгээ сайн уншаад тэгээд асуучих.

Ө.Шижир: 9 сарын 1-нд Улсын Их Хурлын гишүүдэд тараасан Төсвийн тухай ном дээр чинь төсөв дагасан хуулиудын танилцуулга дээр “Эрдэнэс Тавантолгой” компанитай холбоотой танилцуулга байна. Үүн дээр тухайлбал 1 тэрбум ам.долларын үнийн дүнтэй 3-5 удаагийн нүүрсний том арилжааг амжилттай зохион байгуулаад дэнчин хэлбэрээр 250-300 орчим тэрбум ам.долларыг Монгол Улсад татан төвлөрүүлэх боломжтой гэхчхэн байна. Тэрбум доллар шүү. 250-300. Тэгээд энэ чинь, энэ тооцооллоо яриад өгөөч гэхээр хариулах хүн байхгүй байгаад байна. Хэн нь хариулах юм бэ? 250-300 тэрбум ам.доллар Монгол Улсад орж ирэх юм байна. Яаж, ямар тооцооллоор?

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Тэр “Бортээг”-ийн орд бол “Эрдэнэс Тавантолгой” компанийн харьяа лиценз байдаг. Энэ ордын төрийн эзэмшлийн хувийг хэрэгжүүлдэг газар нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байдаг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сайд Бямбацогт хариулах ёстой. Ний нуугүй үнэнийг хэлэхэд Монгол Улс 2 Уул уурхайн яамтай болоод удаж байна. Эрхэм гишүүд бас энэ зовлонг ойлгож, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам буюу уул уурхайн салбар хариуцаж байгаа сайдаас, Эрдэнэс Монгол болон, Эрдэнэс Монгол болон Эрдэнэс Тавантолгойтой холбоотой асуултыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сайдаас асууж байвал их зүгээр байгаа юм шүү. Би энэ асуудлыг засуулах гээд их олон удаа ярьж байгаа. Тэр “Бортээг”-тэй холбоотой асуулт.

Алттай холбоотой асуудал дээр би бас хэлье. Яг одоогийн байдлаар гүйцэтгэл 6.8.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууна.

Д.Пүрэвдаваа: Оройн мэндийг хүргэе. Ажлын хэсгээс хэд хэдэн асуулт асууя. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай гээд энэ дагасан хууль орж ирсэн. 26 оны 1 сарын 1-нээс гэдгийг ажлын хэсэг 10 дугаар сарын 1 болгож өөрчлөх санал гаргаад дэмжигдсэн байгаа. Тэгээд би Сангийн яамнаас асуух гээд байгаа юм манай төсвийн жил чинь 1 сарын 1-нээс 12 сарын 31-нээр тооцогдож явдаг хуультай. Гэтэл 10 дугаар сарын 1 байх нь хууль зөрчиж байгаа юу, ямар нэгэн бизнес ч бай, төр ч бай энэ чинь бүх л цаглавар нь жилээр явдаг шүү дээ. Улирлаар. Тэгэнгүүт чинь энэ чинь бүр улирлаар ч биш 10 сарын 1-нээс гээд ийм хагас жилээр тооцох ч боломжгүй ийм нөхцөл байдлыг оруулж ирж байна. Энэ дээр тодорхой хариулт авмаар байна.

Хоёрдугаарт нь юу вэ гэхээр зэрэг 26 оны татварын жилд сая төгрөг хүртэлх төгрөгийн худалдан авалтад 50 хувь, саяас дээш нь 20 хувийг буцааж өгнө өө гээд

ингээд тооцсон байгаа юм. Тэгэнгүүтээ энэ 26 оны улсын төсвийг тооцохдоо та бүхэн маань энэ төслийг батлагдана гэж тооцож орж ирсэн байх гэж ойлгож байна. Зөв үү? Тэгэнгүүтээ ажлын хэсэг дээр болохоор 10 сарын 1-н болгож хойшлуулж байгаа нь энэ уялдаа холбоо, логикийн зөрчил үүсэх үү? Энийг тайлбарлаад өгчих.

Гуравдугаарт нь юу вэ гэхээр зэрэг 26 он болон 27 онд хэчнээн хэмжээний эх үүсвэр төсөвт төвлөрүүлэх ёстой байсан тэр эх үүсвэр энэ татварын хөнгөлөлт нэмэгдүүлснээр хасагдаж байгаа юм. Үүнийгээ аудит болон Тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцсэн үү, дүгнэгдсэн үү гэж асуумаар байна.

Дараагийн дугаарт энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд энэ танилцуулга дээр нь 4.4 их наяд төгрөгийн 12 төсөл, арга хэмжээ ирэх жилд хамруулна гэж танилцуулга дээр тусгасан байна. Энэ 12 төсөл нь нэлээн том л төсөл байж таарах гээд байх шиг байна. Ерөнхийд нь зарчмын хувьд энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжиж байгаа юм. Гэхдээ нөгөө орон нутгийн болон ТӨК-удын хийж байгаа үйл ажиллагааг хувийн хэвшил рүү шилжүүлэх энэ үе шатаа яагаад орхигдуулсан бэ? Миний ойлгож байгаагаар 300-400 орон нутгийн өмчит компаниуд огт ашиггүй ажилладаг. Дээрээс нь маш их хэмжээний татвар төлөгчдийн мөнгөөр санхүүждэг энэ нөхцөл байдлыг үе шаттайгаар багасгана, дээрээс нь энэ хувийн хэвшил рүү шилжүүлнэ гэдэг бодлого чинь энэ удаад яагаад орхигдов? Тэгээд энэ Түншлэлийн тухай хуульд жижиг, дундынхны оролцоог хэрхэн зохицуулсан бэ? Минийхээр огт зохицуулаагүй. Яагаад орхигдсон шалтгааныг үндэслэлтэйгээр тайлбарлаж өгнө үү? Тэгээд тодруулъя.

Б.Пүрэвдорж: Ням-Осорын Учрал гишүүн, сайд хариулъя.

Н.Учрал: Энэ ирэх оны төсвийг оруулж ирэхдээ төсвийн гол бодлого бол хувийн хэвшилд орон зайг бий болгох, төрийн оролцоог багасгах ийм зорилгыг агуулсан. Энэ зөвхөн ийм зорилго агуулаад зогсохгүй бас тодорхой төсвийн хүрээн дээр бодлогоо оруулж өгсөн нь юу вэ гэвэл төсвийн тэнцвэржүүлсэн орлого татвараар бүрдэж байгаа тэр орлого нь нэрлэсэн ДНБ-ий харьцаа нь бараг 37 хувь байсныг үе шаттайгаар бууруулах зорилготойгоор энэ удаа ирэх жил 30 хувь хүртэл бууруулна. Тэгээд 29, 28 гээд шатлалтай бууруулахыг оруулж ирсэн.

Тэгэхээр яагаад энэ орон зайг бий болгоод байна вэ гэхээр энэ орон зайд татварын шинэчлэлийг хийх гэж зорьж байгаа. Тэгэхээр 4-5 их наядын татварын шинэчлэлийг хийхийн тулд энэ орон зайн дээр энэ татварын шинэчлэл хийгдэнэ. НӨАТ-ын хууль ч гэсэн энэ орон зай дотроо багтаж байгаа гэж хэлж болно. Тийм учраас энэ legal info дээр тавигдчихсан байгаа Татварын багц хуулийн шинэчлэл эхлээд төсөв дээр энэ орон зайг бий болгосноор хэрэгжих бололцоо үүснэ. Тийм учраас төсөв батлагдаад үргэлжлүүлээд бид нар Татварын багц хуулийг хэлэлцэж эхэлнэ гэж зорьж байгаа. Тэгэхээр энэ орон зайг бий болгоогүй тохиолдолд бид нар татварын шинэчлэл хийж чадахгүй. Тэгэхээр НӨАТ-ын хуулиа ч гэсэн хэрэгжүүлэхийн тулд энэ шинэчлэл хийх орон зайн дээрээ тооцоо хийж оруулж ирсэн гэдгийг хэлье.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гол олон улсын жишиг томоохон энэ мега төслүүдийг хийхэд чиглэдэг. Тийм учраас тухайн том төслүүд нь хэрэгжсэнээр энэ ЖДҮ-үүдийгээ дэмжих хувийн хэвшилд ажил гүйцэтгэх

боломжоор хангадаг. Ингээд хувийн хэвшилд байгаа ажлын байруудыг хадгалж үлдэхэд чиглэдэг. Тийм учраас Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль ингэж илүү хялбар үе шат нь буурснаараа энэ зах зээлд төр оролцох, хувийн хэвшилтэйгээ өрсөлдөх энэ байдлыг хална. Зөвхөн төсвөөс дэмждэг биш түншлэлийнхээ хуулийнхаа зарчмаар аймаг орон нутгууд бие даагаад дэд бүтэц нийтийн үйлчилгээний чиглэлийн нийтийн зориулалттай дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлээд эхлэх бололцоо нутгийн өөрөө удирдах байгууллага нь өөрөө шийдсэнээрээ хэрэгжээд явна гэж ойлгож байгаа.

Төрийн өмчийн компани бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль, нийтийн өмчийн хууль Их Хурал дээр хэлэлцэх эсэхийг дэмжсэн байна. Анхны хэлэлцүүлэг хийгдээд дууссаны дараа нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах, нээлттэй компани болгох асуудлыг Засгийн газраас ТӨК дээр баримтлах чиглэлтэй хамт орж ирнэ. 5 салбараас бусад тохиолдолд төрийн өмчийн компани байгуулахыг хуулиар хориглоно. Ингэснээрээ тодорхой өөрчлөлт гарна.

Б.Пүрэвдорж: Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: НӨАТ-ын асуудлаар хариултаа авч чадсангүй. Юу вэ гэхээр зэрэг ажлын хэсэг дээр 10 сарын 1 гэдэг санал гаргагдаад дэмжигдсэн. Би тэрэнтэй нь санал нийлээгүй байна. Энэ хуулийн өөрчлөлт хамт орж ирж мэдүүлэгдэж байгаа учраас 1 сарын 1-нээс хэрэгжээд тэгээд орлого, зарлагаа тооцсон гэж ойлгож байгаа. Гэтэл 10 сарын 1 болж өөрчлөгдөх юм бол энэ орлого, зарлага дээр чинь нөлөө үзүүлэхгүй юү? Энийг яагаад тайлбарлаж өгөхгүй байгаа юм бэ?

Дараагийнх нь зүйл юу вэ гэхээр зэрэг төр, хувийн хэвшлийн түншлэл гэхээрээ энэ 4.4 их наяд төгрөгөөр 12 л том төсөл тэгээд л том компаниудаа л дэмжсэн яг шийдвэр болох гээд байна л даа. Өнгөрсөн жил бас татвараас чөлөөлнө гээд л зөвхөн том компаниудаа дэмжсэн шийдвэр гаргаж байсан. Тэгээд яг бодит үр дүн ингээд 22 оноос хойш гарсангүй. Тэгээд энийгээ бас жижиг, дундаа яг бүүр тодорхой зааж өгч.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. 9 сарын 1-нд өргөн барьсан Засгийн газрын 2026 оны төсвийн хуулийн төсөл дээр маш ойлгомжтой байгаа. Багц хууль буюу 3 төрлийн татвар гэсэн үг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ-ын хууль ингээд манай татварын суурь хууль.

Тэгэхээр НӨАТ бол аж ахуйн нэгж компанийн уг нь хуулийн үзэл баримтлал нь компанийн тухай, компанид очдог ийм татвар биш. Энэ бол хэрэглэгчийн татвар юм байгаа юм. Одоо НӨАТ-аас болж аж ахуйн нэгжүүд дээр дарамт ирээд байгаа нь энэ систем маань өөрөө болохгүй байна гэсэн үг. НӨАТ-ын систем маань. Тийм учраас энийг бүхэлд нь өөрчлөхөөр НӨАТ-ын мөн хуулийн багц өөрчлөлтийг бэлэн болгосон. Ямар ч байсан 2026 онд эхлүүлэе гэдэг дээр саналаа боловсруулаад хуулийн төслөө өргөн барьсан.

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут өгье. Хариулъя.

Б.Жавхлан: Тийм учраас эхний удаагийн өөрчлөлт нь яг хэрэглэгч рүүгээ чиглэсэн байгаа. Энэ НӨАТ-ын хууль НӨАТ-ын татвар маань өөрөө тийм регресив шинж чанартай ийм татвар байдаг. Өөрөөр хэлбэл бага хэрэглээн дээрээ их өндөр дарамттай, өндөр хэрэглээн дээрээ бага дарамттай ийм шинжтэй ийм татвар байдаг. Тийм учраас хувь, хэмжээг хэрвээ жигд буулгачих юм бол энэ нь бүүр эсрэгээрээ болно. Харин ч бүүр том хэрэглэгчид дээрээ дарамтыг нь бүүр улам багасгаад, жижиг хэрэглэгч нар дээрээ дарамтыг нь ихэсгэх болчихно.

Тийм учраас аль болох бага хэрэглэж байгаа хэрэглээн дээр нь илүү хөнгөлөлт үзүүлэх ийм хэлбэрээр оруулж ирсэн байгаа. Энэ нь мэдээж нэлээн өндөр өртөгтэй. Өндөр өртөгтэй. Тийм учраас ирэх жилийн хуулийг өргөн барьснаас хойш Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдаад энэ цалин, тэтгэвэр, тэтгэмж дээр 884 тэрбум төгрөгийн нэмэлт.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн байхгүй байна. Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Энэ Монгол Ардын нам өглөө, Жавхаа сайд аа би юм ярьж байна. Монгол Ардын нам өглөө 14 цаг хүртэл завсарлага авсан. Завсарлагаа сунгаад 15:30 болсон. Тэгээд энэ чинь яасан ийснээ ярьж хэлж энэ чуулганаа үргэлжлүүлдэггүй юм уу? Асуудал нь төсөвтөө биш юм шүү. Их Хурлын дэд даргаа томилуулж чадахгүй, сандал суудлынхаа асуудлыг шийдэж чадахгүй ингээд төрийн ажлыг гацаагаад тэгээд завсраар нь хувь гишүүд орж ирж худлаа попроод ингээд л Ардчилсан нам ажил гацаагаад байгаа юм шиг Ардчилсан намаас болж төсөв гацаад байгаа юм шиг ийм нийгэмд худлаа юм гардуулахаа боль. Энд хэн сууж байна вэ? Ардчилсан намынхан бүгдээрээ л сууж байна шүү дээ. Энд Ардын намынхан энэ байхгүй байна. Би сая Сандаг-Очир гишүүн, Сайнзориг гишүүн хоёрын тэр ярьж байгаа зүйлийг сонслоо. Ардчилсан нам Төсвийн байнгын хороон дээр асуудлыг шийдээд ороод ирсэн юм шиг юм яриад байх юм. Төсвийн байнгын хороон дээр чинь 30-аад хүн байдаг шүү дээ. Тэгээд манайхаас 9-хөн л хүн байдаг шүү дээ. Та нар тэгээд 20-иулаа байж байж бид нарт дийлдлээ юу, яагаад ингээд худлаа ярьдаг юм? Дээр нь 1, 2 зуугаад тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг Ардчилсан нам дээр тавьчихсан байна гээд. Энэ нь чухам үнэн л дээ. Нийт төсвийн 3 хувь байгаа юм.

Тэгэхлээр бид нар нийт төсвийн 97 хувийг өөр дээрээ тавиулчихсан юм аа гэдгээ улс орон даяар зарлаж байна шүү дээ. Та нар угаасаа ингэж л явдаг л даа. Өнөөдөр нийгэм болохгүй болчихсон юм шиг сонин сонин юм яриад байх юм. Нийт 32 жилийн 28-д нь төр бариад л ийм түвшинд авчирчхаад байгаа шүү дээ. Тэгээд бид нар ч харин тэвчээртэйгээр та нарын зодооныг, та нарын зодооныг 2 сар гаруй ард түмэнтэйгээ харлаа. Амьтны хүрээлэнд байгаа юм шиг л загнах юм та нар. Төсвийг бодлогоор зохицуулдаг. Та нар үнэхээр 100 гаруй жилийн настай нам юм бол ардчилсан сонгуулиас хойш 32 жилийн 28 жилийг нь төр барьсан юм бол энэ цалин цагааг чинь эгээ нэг дээрэм тонуулын аргаар нэмдэггүй юм. Энэ чинь та нарын хөгжлийн хөтөлбөр, бодлого, зорилтдоо зориулж нэмдэг шүү дээ. 16-20 онд 64-ийн бүлэг байсан. 20-24 онд 62-ын бүлэг байсан. 24-өөс одоо 68 байна. Тэгээд 2 тасарч хуваагдчихаад хэчнээн сар, жилээр муудчихаад ингээд Ардчилсан нам руу худлаа ярихаа боль.

Сандаг-Очир гишүүн, Сайнзориг гишүүн хоёр яг хэлээд байна шүү дээ. Ардчилсан намынхныг яаж ийж байгаад 200-гаад тэрбум төгрөг тавиулчихсан гэдэг чинь нийт төсвийн 3 хувь, бид нар 97 хувийг нь хуваагаад авчихсан юм. Энэ хэдэд юу ч өгөхгүй байх ёстой байсан чинь харин 3 хувийг тавьчихсан байна хөөрхий минь ингэж хэлж болох юм уу? Тийм. Тэгэхлээр та нар асуудал нь завсарлага авсан бол орж ирээд төсвөө үргэлжлүүлэх ёстой байсан. Их Хурлын дэд дарга, Их Хурлын дэд даргатай л байсан шүү дээ та нар. Үндсэн хууль зөрчөөгүй бол өнөөдөр тэгээд удирдаад аваад явах л байсан шүү дээ. Болохгүй гэсээр байтал болно оо гэсээр байж байгаад Үндсэн хуулиа дэвсэлж хаячхаад тэгээд дараагийнхаа дэд даргыг бас хууль зөрчиж тавиулах гээд байгаа юм. Хэзээ байхдаа та нар ийм болчихсон юм. Та нар 28 жилд цоожгүй складад ороод л иддэг. Энийгээ л 100 хувь идүүлсэнгүй энэ хэдэд бас ер нь хөрөнгө оруулалт гэдэг чинь бид нар гадаадад юм баръя гээгүй шүү дээ. Монгол Улсын хаа нэгтээ хөрөнгө оруулъя л гэж байна шүү дээ. Тэгээд аль нэгэн аймагт жоохон сургууль юм уу, цэцэрлэг тавьчихсан байна. Юуг нь өгчих гээд байгаа юм. 100 жилийнхээ ойг хийж байгаа сум эсгий гэрт цэцэрлэг нь явж байна. Тэгээд тэн дээр цэцэрлэг тавиад өгчхөөч гээд хэлэх нь яагаад та нарын зэвүүг хүргээд байгаа юм?

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж хэлье тодруулъя.

Ж.Батсуурь: Тийм учраас худлаа ингэж матрын нулимс унагадгаа боль та нар. Төсвийн байнгын хороон дээр та нар ямар шийдвэр гаргая гэвэл 30-аад гишүүний 20-иод нь байж байна. Бүх бодлого зохицуулалтыг бүх Байнгын хороон дээр хийвэл болж байна. Өнөөдөр гөлөг төөрүүлж байгаа юм шиг 1 сарыг авлаа. Тэр Эрдэнэбат гишүүнд би үг хэлэх гэсэн юм гараад явчихсан байна. Төсөв, цалин нэмье гэнгүүт гадагшаа гараад попордог. Гүйж орж ирэнгүүтээ өө тэрийг үгүй болгочихъё, энийг үгүй болгочихъё ямар ч судалгаа, тооцоо байхгүй далайн дээрэмчин шиг загнаж байгаа байхгүй юу. Ингэж төсөв баталдаг юм уу ингэж төр барьдаг юм уу? Тэгээд бүгдээрээ хаяад уруулаа унжуулаад алга болчихно. Тэнд би Учрал сайдыг, бас Жавхаа сайдыг энд орж ирсэн сайдыг баярлаж байна. Тэгэхдээ та нар орж ирснийх нь буруу биш хариулт өгөөд би ахиад тодруулъя гэж бодож байна. Монголын төрөөр 28 жил тонгоччихоод тэгээд сүүлийн 2 жил 2 сар амьтны хүрээлэн шиг загначхаад тэгээд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Ер нь хэлж байна шүү дээ. Нийтдээ улсын төсвийн шууд хөрөнгө оруулалтаар 2026 онд 3.2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байгаа. Дээрээс нь 1.9 их наяд төгрөгийн тусламж, зээлээр хөрөнгө оруулалтыг санхүүжүүлдэг. Нийтдээ 5.1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг ирэх жил тавьж байгаа. Тэндээс энэ Ардчилсан намын гишүүд энэ Засгийн газрын түвшинд ямарваа нэгэн тийм хөрөнгө оруулалтыг тавьж чаддаггүй 1 ширхэг ч. Энэ улсын төсөв батлах бол маш том Үндсэн хуулийн дараа ордог хамгийн том эрхүүдийн нэг.

Тэгээд энэ дээрээ орон нутгийн нэр дэвшигч гарч ирсэн тэр хүмүүс орон нутгийнхаа хөрөнгө оруулалтын асуудлыг шийдэж тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг тавьдаг. Энэ нь Ардчилсан намын гишүүдийн хувьд яг ингээд тоогоор нь хэлчихье. 190 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг орон нутагтаа тавьсан. Энэ нь улсын төсвийн 26 онд хийгдэж байгаа нийт 5.1 их наядын дөнгөж 3.8-хан хувь нь, 3.8-хан хувь. Ардчилсан нам бол 42-уулаа 3-ны 1 нь энд сууж байгаа. 33 хувь нь сууж байгаа. Гэтэл ингээд 3.8 хувийн, нийт хөрөнгө оруулалтын

3.8 хувийг л тавьсны төлөө ийм хачин зүйл ярьдаг нь бас буруу гэж бас та бүхэнд хэлмээр байна.

Жамбалын Ганбаатар гишүүн. Асуултад хариулна Жавхлан гишүүн сайд хариулъя.

Б.Жавхлан: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Бүлэг хуралдаж байна. Энд завсарлага дууссан. Бид орж ирээд хурлаа үргэлжлүүлж байна. Бүлэг бас тэндээс биднийг дуудаад 2 талд дуудагдаад ингээд чуулганаа хүндэтгээд энд орж ирээд сууж байна шүү Батсуурь гишүүн ээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, миний лав сууж байсан энэ 3 парламентын хугацаанд энэ хөрөнгө оруулалтууд их айхтар улс төржөөд Ардчилсан нам, Ардын нам гэж хэт их тийм юм ялгараад явсан юм байхгүй шүү дээ. Тийм юм байхгүй шүү дээ. Хэт ялгарсан тийм юм байхгүй шүү. Ардчилсан намынхныг цөөнх байх үед бид яаж хүндэтгэж, яаж энэ хөрөнгө оруулалтуудыг бодлогууд нь яаж явж байлаа одоо байсан гишүүд өөрсдөө бас энийг бас шударга хэлэх хэрэгтэй шүү. Пүрэвдорж гишүүнээ та ч гэсэн дарга хурал даргалж байна. Хоёулаа гурав дахь парламентдаа цуг сууж байна. Та сонгуулиар очоод энэ миний тавьсан хөрөнгө оруулалтууд энэ бид нар ингэж ингэж ажилласан юм гээд зөндөө л юм яриад явах боломжууд нь гарч л байсан байх. Ор тас биш юм тийм юм гэж ерөөсөө байхгүй шүү.

Тэгээд хөрөнгө, одоо жишээ нь 2026 онд орж ирж байгаа энэ 8.8-аас чинь 3.2 нь л улсын төсвийн хөрөнгө оруулалт байгаа. Үргэлжилж байгаа нь 2.2, шинэ нь 1 их наяд гарантай л байгаа. Энэ дотор л ярина л даа. 1 их наяд гэдэг дүн дотор л ярина. Шинээр эхлэх гэж байгаа хөрөнгө оруулалтуудыг. Тэгэхээр 3 байна уу хэдэн хувь байна? Яах вэ тэр хувийн тэр тоо тэрийг би их маргалдмааргүй байна. Хөрөнгө оруулалт л бол хөрөнгө оруулалт. Тантай тэр санал нэг байна. Гадаадад хөрөнгө оруулалт хийх гэж байгаа биш Монголын ард түмэнд л үлдэх ёстой. Монголын ард түмэнд л төрийн үйлчилгээ хийх гэж байгаа л ийм л байшин барилгын чинь л хөрөнгө оруулалт шүү дээ. Тийм, тэгэхээр хэдүүлээ ямар нэг аргаар, ямар нэг байдлаар хуульдаа нийцүүлээд төсвөө урагшлуулъя. Одоо бид нар чинь 5 хэлэлцүүлэгтэй болчихсон. 55 хоног алдсан шүү дээ. 9 сарын 1-нд өргөн барьчаад бид нар 10 сарын 17-нд дөнгөж 2 дахь хэлэлцүүлгээ хийсэн. 10 сарын 22 хүртэл Байнгын хороо Улсын Их Хурлаас баталж өгдөг ажлын хэсгээ хүлээгээд аргаа бараад Байнгын хороон дээрээсээ батлаад ингээд өнөөдрийг хүртэл явж байна. Энэ ажлын хэсэг сайн ажилласан. Ёстой чадахаас нь чадахгүйг хүртэл ажиллаж байна маш хүнд нөхцөлд. 9 сарын 1-нд Засгийн газрын өргөн барьсан. Тэрнээс хойш энэ 2 сарын хугацаанд улс төрийн нөхцөл байдал одоо маш хүнд болсон. Гадна талдаа ч тэр, ордон дотор ч тэр. Ингээд аль болох олон нийтийн тавьж байгаа энэ шаардлага бас хамгийн олон санал авч энэ салбараа хамгийн их анхаараарай гэсэн энэ боловсролын салбарыг, мөн эрүүл мэндийн салбар энэ бүхнийг арайхийж бас тавьж байгаа шаардлагуудыг нь багтаах гэж энэ ажил.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя. Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Жавхаа сайдад баярлалаа. Би ажлын хэсгийг муу ажилласан гээгүй. Үнэхээр сайн ажилласан. Ажилласан ч учраас энэ асуудлуудыг буюу гаргаж

ирсэн байх гэж ингэж бодож байна. Яг үнэндээ улс төржилтийг бид биш тодорхой ингээд хүмүүс хийгээд байгаад үнэхээр сэтгэл дундуур байж байна. Ардчилсан нам хууль зөрчиж төсөвт мөнгө тавиулах боломж байхгүй. Та нар 68-уулаа байж байж бид нарыг хууль зөрчүүллээ юү, зөрчүүллээ юү? Тийм учраас би танай бүлгийг хуралдаж байгаа, та нар танай бүлэг дээр би төсөв ярьж байгаа гэдэгт итгэхгүй байна. Яаж дэд даргаа тавиулах вэ? Яаж төсвөөр бойкотолж дэд даргатай болох вэ? Аль бүлэглэл нь дийлэх вэ, 15-наас өмнө төсөв маань ч гайгүй, ард түмний тэр цалин цагаан маань ч гайгүй аль нь дийлэх вэ гэдгээ л тэн дээр ярилцаад сууж байгаа гэдэгт би бат итгэл.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Санал хэлсэн.

Тэгэхээр сая энэ Батсуурь гишүүний хэлж байгаатай би бас санал нэгдээд нэг зүйлийг хэлмээр санагдаж байна л даа. Жавхлан сайд аа би энэ миний энэ 2024 оны төсөв дээр 2023 оны 11 сарын 4-ний өдөр энэ чуулганы индэр дээрээс хэлж байсан энэ Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дүгнэлт байна. Тэгээд энэ дээр би жоохон юмыг уншаад өгчихье. Төсвийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын хуваарилалт, байршуулалт жигд, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх зарчим бүрмөсөн алдагдлаа. Үүнийг Хэнтий аймгийн 1 хүнд ноогдох төсвийн хөрөнгө оруулалт 14 сая 507 мянган төгрөг байна.

Гэтэл Өмнөговь аймгийн хувьд 541-хэн мянган төгрөг. Орхон аймагт 931 мянган төгрөг хуваарилагдаж байна. Тэгээд энэ ингээд энэ дүнгээрээ үзэхэд тухайн үед 87 мянган хүнтэй байсан Хэнтий аймаг. Тэр жил нийт хөрөнгө оруулалтын дүн нь 1 их наяд 180 тэрбум байсан шүү дээ. 1 их наяд 180 тэрбум. Тэгээд өнөөдөр энэ зарим нэгэн хөрөнгө оруулалтууд нь явагдаад дуусаад энэ улсын төсөв дээр чинь Хэнтий аймгийн 26 төсөл, арга хэмжээ байгаа. Тэнд 721 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тавигдчихсан ингээд төсвийн зарчим алдагдсан. Дарга нар чинь болохлоор ингээд тавиад байдаг.

Тэгээд энэ Ховд аймагт, баруун 4 аймагт 20 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тавьсан юм л даа. Тэр нь жишээ нь энэ Амгаланбаатар гишүүн 3 тэрбум төгрөгөөр Говь-Алтай аймагт ийм ийм ажил хиймээр байна гэдэг зүйл яриад, Түвшин гишүүн бас Завхан аймагт 3 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалтын ажил хиймээр байна гэж хэлээд, дээрээс нь таны ард суудаг Заяабал гишүүн, урд чинь суудаг Чойжилсүрэн гишүүн хоёр хоёулаа Увс аймагт Улаан-Уул руу явдаг зам нийтдээ 3 орчим тэрбум төгрөгөөр тавигдах юм. Тэрийг та хөрөнгө оруулалтаар тавьж өгөөч гээд. Ийм ингээд олон гишүүдийн хамтарсан тэр зүйлийг л би өөрийн нэрээр гаргаж байгаа болохоос биш энэ 20 тэрбум төгрөг их тийм их биш шүү дээ. Энэ чинь тэгээд танай намын даргын тухайн үед хийж байсан тэр 14 сая 500 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын хувьд тэр Ховд, Увс, Завхан, Говь-Алтайн бүх иргэдэд хуваах юм бол 50-хан мянган төгрөг байхгүй юу даа.

Тийм учраас та нар энэ өөрсдийнхөө энэ Засгийн газар дээр байгаа энэ хөрөнгө оруулалт замбараагүй тавигддаг энэ Монгол Ардын нам бас яг 9 жилийн хугацаанд үнэхээр Жавхлан гишүүний хэлсэнчлэн тийм айхтар юу байдаг юм Ардын нам, Ардчилсан нам гэж хуваахгүйгээр бас төсвөө бас хөрөнгө оруулалт энэ тэрээ аятайхан тавьж байсан. Ямар ч хэл ам гарч байгаагүй. Ийм их хөрөнгө оруулалт хийж байхад би тухайн үед шүүмжлээд өнгөрч байсан болохоос биш

өнөөдрийнх шиг ингэж төсөв барьцаалж хэн нэгэн хүн, албан тушаалтныг тавих тухай асуудлыг ярьж ингэж улс төржиж байгаа шүү гэдгийг бас хэлмээр байна.

Дараагийнх нь Жамбалын Ганбаатар гишүүн байхгүй байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууна.

Б.Мөнхсоёл: Төсөв, төсвийг дагалдан орж ирсэн хуулиудтай холбоотой олон асуудлыг ярьж болж байна. Тэгээд өнөөдрийн энд төсөв тойрсон олон маргаантай, мэтгэлцээнтэй байдлууд ч гэсэн энэ миний одоо асуух гэж байгаа асуулттай холбоотой гэж бодож байна. Төсвийн орлого гэж байна. Зарлага гэж байна. Төсвийн орлогыг маш сайнаар оруулах, өндөр орлоготой байх нь мэдээж улсын хувьд чухал. Тэгээд энэ дотроо төсвийн орлого чинь өөрөө нэг талдаа татварын орлого, нөгөө талдаа татварын бус орлогоос бүрдэж байгаа.

Гэтэл бид нар олон жил татварын орлого дээр л анхаараад байдаг 80 гаруй орчим хувийг нь татварын орлогоор бүрдүүлээд байдаг. Харин үлдсэн нөгөө татварын бус орлого дээрээ анхаарахгүй байна. Энэ хэсэгтэй холбогдуулаад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ асуудал орж ирсэн. Үүнтэй холбогдуулаад миний хэлэх гээд байгаа санаа нь олон жил ч яригдсан асуудал. Нөгөө төрийн өмчит үйлдвэрийн газруудыг хувьчлах асуудал яагаад яригдахгүй байна, нөгөө төрийн болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрүүдийн газруудын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх асуудлууд яагаад яригдахгүй байна. Авлагыг бүр бүрдүүлэх энэ асуудал яагаад яригдахгүй байна гэдгийг асуумаар байгаа юм.

2023 оны эцсийн байдлаар нөгөө толгой 86 компани, охин компаниудыг нь оролцуулаад 109 компани байна гэж байгаа юм. Эд нарын алдагдалтай байдлынх нь хувь, хэмжээ 43 хувьтай ийм байдалтай байна. 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд болохоор эдгээр компаниудаас оруулах хувьцааны ноогдол ашгийг дөнгөж 540 тэрбумаар тооцсон байна. Улсын төсөвт энэнээс дөнгөж 80 тэрбум төгрөгийг оруулна гэчихсэн гэх мэт байдлаар энэ асуудлуудыг яриад байвал олон тоо баримт дурдаж болж байна. Энэ асуудлыг яагаад олон жил даамжруулаад шийдэхгүй яваад байна. Зөвхөн татварыг өсгөх байдлаар энэ асуудал нөгөө зарлага тал чинь шийдэгдэхгүй байна шүү дээ. Зарлага талдаа төсвийн сахилга бат яригдана. Оновчтой, өгөөжтэй зарцуулалт яригдана. Нөгөө цалин, тэтгэвэр өсгөх энэ асуудлууд жил дараалан яригдаж байна шүү дээ. Өнөөдөр ийм хямралтай байдалд хүргэсэн байна. Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт авъя гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах билээ? Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ удаа энэ Төсвийн хүрээг оруулж ирэх дээр энэ макро тоонуудаа хатуу барья л гэж зорьсон. Нэг ёсондоо Занданшатарын Засгийн газар байгуулагдаад Эдийн засаг, хөгжлийн яам энэ төсвийн хүрээгээ боловсруулахдаа энэ макро 9 тоогоо үнэнээр нь бодитоор нь оруулъя гэж зорьсон. Тэгэхээр орон зайг гаргахын тулд хийсвэрээр орлого төлөвлөдөг. Ингээд орон зай бий болгодог тэгээд ДНБ-ээ нэмэгдүүлдэг ингээд хөрөнгө оруулалтуудыг шингээдэг. Энэ байдлыг бид нар таслан зогсоох ёстой. Ингээд хиймэл, хийсвэрээр ийм орлого төлөвлөөд орон зайд нь хөрөнгө оруулалт хийгээд явахаар хэд хэдэн удаа тодотгол хийдэг. Дээрээс нь төсвийн сахилга бат хариуцлага алдагддаг. Тийм ч

учраас энэ нөгөө орлого нэмэгдүүлье гэхээр татвараас өөр арга замгүй, татвараа нэмэгдүүлснээрээ орлогоо их өөдрөгөөр төсөөлчихдөг. Тэгээд эхлэхээр тэр тэнцвэржүүлсэн орлого GDP-ийн харьцаа нь ингээд 37 хүрээд эхлэхээр хувийн хэвшил ажиллах ямар ч орон зай байхгүй. Тийм учраас энэ харьцааг бууруулж чадах юм бол энэ дунд тэр нөгөө татварын шинэчлэл хийх юм байна л гэж зорьсон.

Тийм учраас сая Их Хурал ажлын хэсэг байгуулан ажиллалаа. Энэ хүрээнд ч гэсэн зүгээр Засгийн газрын зүгээс бид нар энэ макро тоон дээрээ хөдөлгөөн байхгүй. Нэгэнт Их Хурлын баталсан орлого, зарлага нэгэн зэрэг буурч байгаа тохиолдолд төсвийн хүрээ оруулж ирж болох энэ заалтыг хийсэн учраас бид нар өмнө нь батлагдсан төсвийн хүрээн дээр байсан орлого нь 33.5 их наяд, зарлага нь 33.5 их наяд. Харахад тийм алдагдалгүй төсөв гээд гоё нэртэй яг эргээд харахаар олох боломжгүй орлого төлөвлөчихсөн. Тэгээд зарлага нь яг түүнтэйгээ адилхан зардаг. Тэгэхээр энийг нь аль алиныг нь бууруулъя гэж зориод орлогоо 31.6 зарлагаа 32,980 гээд ингээд оруулж ирсэн. Тэгэхээр энэ бас төсвийн сахилга бат, хариуцлага. Цаашдаа бас ийм төсөв эрүүлжээд явахад хэрэгцээтэй гэдэг утгаараа хандсан.

ТӨК-удын энэ төвлөрүүлэх орлого буюу үр ашигтай ажиллуулах асуудал мэдээж нээлттэй, ил тод болох асуудлаас эхэлнэ. Тийм учраас Оюун-Эрдэнийн Засгийн газрын үед ТӨК-ийн нөгөө хуулийг оруулж ирчихсэн байгаа юм. Энийг баталчих хэрэгтэй. Тэгээд Засгийн газраас баримтлах чиглэлээ оруулж ирээд татан буулгах асуудлуудаа яриад явчихад угаасаа хуулийнхаа дагуу хэрэгжээд л явчихна. Өнгөрсөн хугацаанд Засгийн газар эрхийнхээ хүрээнд 20 ТӨК-ийг нэгтгэж нийлүүлсэн, өөрчлөн зохион байгуулсан, татан буулгасан.

Б.Пүрэвдорж: Тодруулъя.

Б.Мөнхсоёл: Хариултыг яг сайн ойлгосонгүй. Нэлээн тойруу явчих шиг боллоо тээ? Төсвийнхөө тухай ярьчихсан уу? Яаж хандсан? Хамгийн гол нь миний хэлэх гээд байгаа санаа нь татварын орлогыг заавал энэ хэмжээнд нь барих албагүй шүү дээ. Төсвийн орлого талд чинь татварын орлого, татварын бус гээд ингээд явж байгаа шүү дээ бүтэц нь.

Тэгэхээр харин ч бизнес эрхлэгчдээ боломж олгоод тэр НӨАТ энээ тэрээ гээд хугацааг нь наашлуулах, эсвэл босгыг нь багасгах энэ тэр гээд боломжууд байсан. Тэрнийхээ эсрэг нөгөө талд нь татварын бус орлогоо нэмж болно. Энэ тал дээр яагаад ажиллахгүй олон жил алдчихав? ТӨҮГ-ууд, тэр орон нутгийн болон орон нутгийн өмчит компаниуд чинь ашиггүй ажиллаад байна, алдагдалтай байна, данхар байна, яг өгөөжтэй ажиллаж чадахгүй байгаа юм чинь хувьчилъя гэж энэ асуудлуудыг хөндөөд байна шүү дээ. Энэ аягүй олон жил яригдсан. Зөвхөн энэ уул уурхайн салбарын янз бүрийн компаниуд чинь дотроо хөндөгдөж байгаа ганц хоёрхон л том том аж ахуйн нэгжүүд. Тэрнээс гадна 109 компани. Орон нутгийнхыг оруу.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Учрал сайд тодруулъя.

Н.Учрал: ТӨК-удыг нөгөө дуудлага худалдаагаар олон нийтийн санал болгох, эсвэл татан буулгах, өмчийг нь зарж борлуулах гээд энэ ТӨК-удын

өмчлөлийн орлого бол төсвийн орлого талд нэмэгдэж угаасаа хуулиараа ордоггүй. Төсвийн хуулийн 23.12 байхгүй юу. Өмч хувьчлалын орлогыг төсвийн орлого хэсэгт бүртгэхгүй. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр талд нь бүртгэдэг. Тийм учраас энэ өөрөө нөгөө өмч хувьчлалын орлого бол өөрөө төсвийн орлого хэсэгт бүртгэгддэггүй. Тийм учраас зүгээр яах вэ татварын бус орлого дээр. Жавхаа сайд бас нэмж хариулах байх.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Татварын. Тийм, татварын бус орлого манай дээр өмнө нь Мөнхсоёл гишүүнийг асууж байсан тээ? Чи эхний хэлэлцүүлэг дээр асууж байсан шиг санаад байх юм. Тийм татварын бус орлого манайд их, бага хувь эзэлдэг л дээ. Тэгээд татварын бус орлогыг нэмэгдүүлэх ямар боломж байдаг юм тэрүүгээр төсвийнхөө орлогыг нэмээч гэсэн ийм асуудал хөндөгдөж байсан. Тэгэхээр энэ татварын бус орлого маань өөрөө энэ тогтвортой орлого биш шүү дээ. 1 удаагийн шинжтэй ийм л орлогууд байдаг. Тэрийг бид өндөр орлогын эх үүсвэр гэж төлөвлөх нь өөрөө маш эрсдэлтэй. Хамгийн эрсдэлтэй зүйл. Татварын бус орлогууд нь орж ирвэл сайн л биз. Одоо тэр чинь жишээ нь татварын, торгуулийн орлого байна. Татварын бус орлого. Бид нар аягүй их торгоод өгнө өө тэгээд орлогоо нэмэгдүүлнэ гэлтэй нь биш. Нөгөө талдаа нийгмийн энэ зохион байгуулалт энэ талдаа тэр торгуулахгүй байх нь л нийгэм өөрөө зөв явж байгаа л суурь шүү дээ.

Б.Пүрэвдорж: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Энэ төсвийн өрөө яригдаж байгаа учраас эрчим хүчтэй холбоотой асуух гэж байсан асуултаа дараа нь ярих хэрэгтэй болж таарч байна. Тэгээд энэ намар би манай багш нар нэлээн удаан тэмцэж байж бас арай ядан Засгийн газартай зөвшилцөлд хүрээд цалингаа нэмүүлэхээр болж байгаа. Тэгээд үүний цаанаас бас эмч нар, сувилагч нарын асуудал яригдана. Тэгээд манай улсад бодитоор ажил нугалдаг хүмүүстээ мөнгөн хэлбэрээр мөн цалинг нь өгдөггүй байсан. Тэгээд хамгийн сонирхолтой юм бас харагдаж байгаа юм л даа. Бид нар яг эмч болон багш нартаа энэ олон жилийн турш цалинг нь мөнгөн хэлбэрээр өгөхгүйгээр одон медаль хэлбэрээр өгсөн байдаг. Тэгээд 2024 онд жишээ нь Боловсролын яаманд 7378 ширхэг одон медаль тараасан байгаа юм. Эрүүл мэндийн яаманд 4400 ширхэг одон медаль өгсөн.

Тэгэхээр чинь бид нар чинь нөгөө хүний хөдөлмөрийг бүтээмжээр нь үнэлээд, бодитоор нь мөнгөн хэлбэрээр дүнгээр нь хүнийг урамшуулж цалинг нь олгодог энэ зах зээлийн нийгэмд шилжсэн байтал энэ 2 үндсэн том салбараа бид нар орхигдуулж явсан Засгийн газрын маш буруутай бодлого гэдэг нь харагдаж байгаа юм. Тэгээд хөөрхий минь бусад салбарынхан шиг хөдөлмөрөө бүтээмжээр үнэлүүлж явж чадахгүй ажиллаж байтал Нямбаатар дарга гарч ирээд л автобусны жолооч нар 3.5 сая төгрөг, ТҮК-ийн ажилчид 3 сая төгрөг ч гэдэг юм уу ингээд ирэхээр чинь яаж энэ салбарын хүмүүс тэвчиж ажиллах вэ дээ. Тийм учраас би энэ багш нар, эмч нарын ажил хаялтыг дэмжиж байгаа. Тэгээд энийг бас хэлэхийг хүссэн юм.

Яг үнэндээ бас бодитоор яриад үзэх юм бол хэдэн төгрөгийн цалин яг төгрөгөөр авч байгаа вэ гэдэг нь өөрөө сонин биш байгаад байгаа юм. Тэгээд тэр

авсан цалин маань өөрөө бодитоороо хэрэглээндээ хүрч байгаа юм уу, хэрэглээнээсээ даваад хадгаламжтай болох боломжтой байгаа юм уу гэдэг энэ асуудлыг бид нар харах хэрэгтэй. Засгийн газраас байхгүй мөнгөө бид нар ингээд хэвлээд өгчихдөг. Гэтэл өнөөдөр 3 мянган төгрөгөөр авч байгаа талх нь 5 мянган төгрөг л болоод явчихна. Нөгөө талдаа бид нар хувийн хэвшлийнхнийгээ яах гэж байгаа юм бэ? Хувийн хэвшлийнхэн дагаад цалингаа нэмж чадахгүй. Тэгэхээр одоо энэ 880 тэрбумаар нэмэгдэж байгаа цалингийн зардалтай холбоотойгоор инфляц яг бодитоор юу болж байгаа вэ? Эдийн засаг, хөгжлийн яамны сайдаас асуухад хувийн хэвшлийнхэнд энэ бодлого нь өөрөө яаж нөлөөлөх вэ?

Б.Пүрэвдорж: Хэн түрүүлж хариулах вэ? Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Тэр одон медальтай асуултыг Цэнгүүн гишүүн өөрөө асуудал дэвшүүлээд өөрөө хариулчих шиг боллоо. Би асуултыг нь ойлгоогүй шүү уучлаарай.

Сүүлийн хэсэг дээр нь би хариулъя. 854 тэрбум төгрөг болж байгаа юм цалин, тэтгэвэр нийлээд. Боловсролын салбарынхны 500 гаран тэрбум, тэтгэвэр, эрүүл мэндийн салбар нь нийлээд 300 гаруй тэрбум. Энэ инфляцад нөлөөлнө өө. Хувийн секторт ч нөлөөлнө. Ингээд бүтээмжээсээ түрүүлээд цалин нь ийм өндөр өсчихөөр ер нь эрэлтийн инфляцыг өдөөнө. Дээрээс нь хувийн хэвшлийг чирнэ. Хувийн хэвшил дагаад цалингаа өсгөхөд таарна. Хувийн хэвшил энэ өртгөө бүтээгдэхүүндээ л шингээнэ. Ингээд дараагийн инфляцын ийм шинэ циклийг эхлүүлэх ийм өндөр эрсдэлтэй. 9 сарын 1-нд өргөн барьсан Засгийн газрын бодлогод энэ боломж, төсвийн боломж орлогодоод нийцүүлж хумьж орсон энэ төсөвт маань цалингийн нэмэгдэл үнэхээр багтаагүй. Энэ боломжоо үнэн бодит байдлаа ард түмэндээ хэлсэн.

Ингээд өргөн барьснаас хойш ийм хөдөлгөөн өрнөсөн. Хөдөлгөөн өрнөсөн. Ил, далд ер нь их л олон янзын учир нөлөө байх шиг байна. Тэрийг одоо энд яриад яах вэ. Хэлэлцээр нэгэнт болсон. Засгийн газар хэлэлцээр хийгээд ямар Улсын Их Хурлын гишүүд хэлтэй нь биш Засгийн газар хийгээд бид боломжит тооцооллуудаа гаргаад ажлын хэсэгт буюу Их Хурал руугаа хүргүүлсэн байгаа. Одоо ингээд ажлын хэсэг дээр ингээд яригдаж байна. Уг нь маргааш 3 дугаар хэлэлцүүлэг дээрээ энийг маш тодорхой ярих юм байгаа юм. Тийм учраас хэдүүлээ яаж ийгээд энэ төсвөө үргэлжлүүлээд хугацаанд нь 11 сарын 14-нд ирэх 7 хоногт баталчихвал маш сайн байна.

Б.Пүрэвдорж: Учрал сайд нэмж асуултад хариулна.

Н.Учрал: Ажлын хэсэг дээр энэ багш, эмчийн цалин хөлсийг нэмэх, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх асуудлаар бас ажлын хэсэг ажилласан. Их Хурал дээр тэгэхээр яах вэ нийт зардлаа нэмэхгүй учраас инфляц дээр тийм бас өндөр нөлөө үзүүлэхгүй. Гэхдээ бас цалин хөлс нэмэгдэж байгаа учраас нөгөө өрхийн хэрэглээ болдог гэдэг утгаараа инфляц бага зэрэг бас өдөөнө өө л гэж тооцож байгаа. Тэгэхээр нийт зардлаа нэмээгүйгээр бусад урсгал зардлаасаа танах байдлаар зарим үйл ажиллагаануудыг зогсоогоод тэгээд энэ цалин, хөлсөө энэ төсвийн хүрээнийхээ тоонуудыг хөдөлгөхгүйгээр шийдээд явж байгаа. Нийт зардал нэмэгдээгүй учраас тийм өндөр нөлөө үзүүлэхгүй.

Б.Пүрэвдорж: Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууна.

М.Мандхай: Шинээр орж ирээд МАНАН бүлэг байдаггүй юм байх гэж бодсон чинь МАНАН бүлэг байдаг юм байна гэдгийг энэ төсөв харууллаа гэж хэлмээр байна. Бид нар эдийн засгийг тэлэх биш улс төрийн нөлөөлөлд хөтлөгдсөн тойргийн хуваарилалт болсон төсөв болсон гэдгийг хэлэх хэрэгтэй. Бид уул нь төсөв дагасан хуулийг уялдуулж хэлэлцдэг. Гэхдээ энэ төсөв нь өөрөө бодит хөгжлийн төсвийн бодлогод суурилсан ийм төсөв биш юм. Энийг өнөөдөр хэлэлцээд байх нь ч өөрөө утга алга. Энэ танхимд уул нь бид нар яг энэ танхимдаа орж ирэхдээ энэ нам, тэр нам биш 126 ард түмний өмнө дүнгээ тавиулж байгаа гишүүд гэдгийг анхаарах хэрэгтэй. Тэрнээс биш тэр Ардчилсан нам нь байна уу МАН биш энэ танхимд ороод бүгдээрээ нэг ард түмний төлөөлөл гэдгээ л санах хэрэгтэй. Эмч, ахмадын цалин, тэтгэвэр энэ орон нутгийн нөхцөл байдал, ажилгүйдэл, түлш, бензин шатахууны хомсдол, энэ малын тэжээлийн хомсдол, хүнсний хангамж орон нутагт хүрэлцэхгүй байгаа бодит байдал энэ эрсдэл үгүй энэ чинь амь тэмцсэн асуудал биш юм уу? Энэ төсөв чинь үүнтэй уялдах ёстой юм биш үү? Тэгээд энэ иргэд, аж ахуйн нэгжүүд харж хүлээж байгаа болохоос биш энэ хэдэн МАНАН бүлэг нийлээд энэ мөнгийг нь хасаад тойрогтоо тавихдаа тоног төхөөрөмж, шинэ барилга, байгууламж, хот тохижилтын тоног төхөөрөмж, зам гэсэн төсөв тавьж байгаа юм. Үгүй энэ чинь тэгээд та бүхэнд түлш болоод өгөх юм уу, малын тэжээл болж өгөх юм уу? Эмч нарын цалинг нэмж өгөх юм уу, ахмадуудын тэтгэврийг нэмэх юм уу энэ төсвүүд чинь? Тэгээд энэ чинь яг бодит амьдрал дээрээ уялдсан төсөв мөн юм уу? Тэгвэл бид нар энэ дагах хуулиудыг яриад яах юм. Төсөв чинь өөрөө бодитой амьдралд нийцсэн төсөв биш байхад. Тэгээд өнөөдөр сая ингээд сөрөг хүчин хийх ёстой гишүүн нь өө яадаг юм та нар ингээд тавьж байгаа юм чинь би ч гэсэн өөрөө энэ 200 тэрбум төгрөгийг тэгвэл тойрогтоо тавьсан гээд өөрөө батлаад сууж байна шүү дээ. Би шинээр орж ирсэн гишүүний хувьд үнэхээрийн МАНАН гэж байдаг юм байна гэдгийг өнөөдрийн чуулганаар энэ асуудал дээр үзсэн. МАНАН гэдгийгээ баталлаа гэж хэлмээр байна. Тэгэхээр бид нар энэ бодлогын биш зүгээр энэ сонгуулийн чанартай төсөвтэй улс орон хуулиа яаж ч бид нар энэ төгс болгох юм бэ? Тэгэхээр энэ бодит амьдралд нийцсэн ил тод хариуцлагатай, төсөвтэй болохоос нааш энэ төсвийг дахиад Засгийн газарт нь буцаагаад сайжруулж орж ирэх ийм саналтай байгаагаа хэлэх гэсэн юм.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Хариулна хариулна чухал сэдэв хөндсөн учраас. Та 9 сарын 1-нд Засгийн газар төсөв өргөн барьсан. 9 сарын 1-нд шүү. Өнөөдөр 11 сарын 6. 66 хонож байхад өнөөдөр дөнгөж дагасан хуулийн нэгдүгээр анхны хэлэлцүүлэг хийж байгаа шүү дээ. Бид өөрсдөө буруутай шүү дээ. Одоо ингээд танин мэдэхүйн шинжтэй юм ярих юуны төсөв гэнэ вэ? Ийм хариуцлагагүй байж болохгүй. Хэрвээ Засгийн газар төсвөө буцааж аваад сайжруулж ор гэж байгаа гэж байгаа бол дэгийн хувьд ямар ч боломж байхгүй.

Харин тэрний оронд би ийм санал тавимаар байна Их Хурал төсвөө баталсны дараа дахиад харин Үндэсний аудитын газар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд энэ баталсан төсвөө хүргүүлээд Засгийн газрын өргөн барьсан төсвийг харин сайжруулсан уу муужруулсан уу гэдгийг нь хардаг болмоор байгаа юм. Тэгээд цаашаа явдаг болмоор байна. 66 хоночхоод одоо буцаана гэж яаж

ингэж хэлж чадаж байна аа? Төсвийн хууль өөрөө тусдаа дэгээр явдаг. Засгийн газар саналаараа буцааж авах гэдэг юм уу Улсын Их Хурал буцаах ямар ч боломж байхгүй. 10 сарын 17-нд 26 оны хөгжлийн төлөвлөгөөтэй нийцэж байна гээд Улсын Их Хурал өөрөө дэмжээд гаргачихсан. Хэрвээ буцаах энэ асуудал байсан бол тэр үед нь энийгээ ярих ёстой байсан. Тэрүүгээр дэмжиж гаргачхаад өнөөдөр ийм юм ярьж байна гэдэг өөр шалтгаан байна. Өөр шалтгаан байна. Төсөв ярьж байхад төсвийн ажлын хэсэг энэ дэд даргын асуудал ярих бид нар ямар ч боломж байхгүй шүү дээ. Энэ Төсвийн байнгын хороон дээр энэ дэд даргын асуудлыг ярихгүй, ажлын хэсэг дээр ярихгүй. Энэ чинь 2 шал өөр тусдаа асуудал.

Тэгэхээр Дэгийнхээ хуулиар тус тусад нь энэ асуудлуудаа урагшлуулцгаа гэж гишүүдээ уриалмаар байна.

Б.Пүрэвдорж: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. 66 хоногийн өмнө оруулж ирсэн төсөв 1 ч эмч нарын цалинг, 1 ч багш нарын цалинг нэмэгдүүлэхгүй нойл, ахмадуудын тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэхээр орж ирсэн. Нийгмийн шахалт, шаардлагад хөтлөгдөж сая ингээд юм тодорхой хэмжээний нэмэгдлүүдийг хийсэн. Бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг танан байж 1.1 их наяд төгрөгийг гаргаж ирсэн. Энэ дээр багш нар маань ажил хаялтаа зогсоосон. Гэтэл та бүхэн энэнтэй зэрэгцүүлээд ахиад 1.1 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 363 тэрбум төгрөг 2026 онд санхүүжих дүнтэй 111 төсөл, хөтөлбөрийг шилжих болоод, шинэ хөтөлбөрүүдийг оруулж ирсэн. Энэ үнэн үү гэвэл үнэн. Өчигдөр та бүхэн орой Төсвийн байнгын хороон дээр санал хурааж дэмжигдсэн. Энийг хараад 2 нүд орой дээрээ гайхаж байгаа юм. Багш, эмч нарын цалинг нэмэх ямар ч бололцоогүй, мөнгө байхгүй гэж байсан манай дарга нар яагаад гэнэт ийм эх үүсвэр гаргаад ирэх болов? Энэ цэвэр Засгийн газрыг огцруулах, огцруулахгүй асуудал яригдаж байх үед Ардчилсан намын тодорхой хэсэг нөхдүүд эрх баригч нарыг хамгаалж өвөр түрүүнд нь орж улаан хамгаалагч болж гүйснийхээ төлөө 1.1 их наяд төгрөгөөр тойрогтоо хөрөнгө оруулалтын ажил батлуулж өнөөдөр оруулж ирж байгаа нь энэ. Бид бүхэн Ардчилсан намыг буруутгаагүй. Бид бүхэн эрх баригч нам дотроо энэ Засгийн газартаа хариуцлага тооцъё, ажлаа хийж чадахгүй байгаа сайд нар олон байна гэж ингэж ярьж байсан юм.

Гэтэл сөрөг хүчин маань дийлэнх олонх нь энэ Засгийн газрыг тогтвортой ажиллуул гэж хамгаалаад яваад байсныг бид нар гайхсан. Сөрөг хүчин ингэж ажлаа хийдэг юм уу? 5 дахь өдөр манай Баасанжаргал гишүүн хэлсэн. Та нар эрх ашгийн нэгдэл. Сөрөг хүчин ийм байдаг юм уу гэж хэлж байсан үнэн орой руу чинь орж байгаа байх. Та нар эрх ашгийн нэгдэл. Парламентын засаглалыг нухчин дарах гээд парламент дээр Засгийн газар нь дөрөөлөөд тоглоод байж байхад ийм Засгийн газрыг давраулж та нар орон нутгийнхаа хэдэн тэрбум төгрөгийн тойргийн хөрөнгө оруулалтаар барьцаалж кнопоо наймаалж, Засгийн газрыг авч үлдсэн.

Ийм учраас ийм учраас энэ авлигын төсөв, энэ бол хулгайн төсөв, энэ бол наймааны төсөв гэж би хэлээд байгаа юм. Та бүхэнд үнэн үг хэлсэн хүнд үхэр өшөөтэй байгаа байх, хэцүү байгаа байх. Та нар маань яасан эмзэг юм бэ. Та нарын энэ бүгд манай нам руу дайрч давшлахаараа бүгд захын дуртай хүн нь хэлдэг. Та нарт хэн ч үг хэлж байгаагүй. Та нар яасан эмзэг юм, та нар хүний

олноороо хүнээ барь. Хүн олонхоороо, хүний олноороо хүнээ барьдаггүй юм шүү. Дандаа ийм байхгүй. Та нар ингэж наймаац, би Батсуурь даргаа танай хөрөнгө оруулалтын ажлуудыг би үгүйсгээгүй. Аль ч сум дээр, аль ч аймаг дээр та бид нэгэн цагийн үед орон нутаг удирдаж байсан хүмүүсийн хувьд 1 ч хөрөнгө оруулалтын ажил хийж байвал баярладаг.

Гэхдээ та бүхэн дүрэм, журмын хүрээнд биш наймаацаж, тохиролцож, хөшигний ард хулгайн төсөв баталж ирж ингэж оруулж ирж байгаад яагаад өнөөдөр манай намын бүлэг дотроо хэрэлдээд одоо хүртэл бүлэг дотроо шийдвэр гаргахгүй явж байгаа учир нь энэ. Энэ яагаад хуралд орж ирэхгүй байгаа учир нь энэ. Тэрнээс тэр сандал суудал чухал биш юм байгаа юм. Ийм хулгайн төсөв оруулж ирсэн учраас та нар өнөөдөр Пүрэвдорж дарга долоо хоног дамжуулан энэ суудал дээр сууж байгаад төсвийн хамгийн гол хэлэлцүүлэг гуравдугаар хэлэлцүүлгийг хийж энэ хулгайн төсвөө батлуулаад буух гэж байгаа санаархал нь энэ. Та нарын энэ нууц хуйвалдааныг чинь бид нар алган дээрээ тавьсан юм шиг харагдаж байна. Харж байна. Энэ та нарын оруулж ирсэн 1.1 их наяд төгрөгийн төсөв чинь энэ цаасан дээр байж байна. Тийм учраас та нар энэ хулгай.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Сандаг-Очир гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Тийм учраас би юу гэж хэлэх гэж байгаа вэ гэвэл тодорхой санал хэлье. Та нар маань ичихгүй бол ард түмнээсээ нууж байгаад мөнгө байхгүй гэж байсан нууж гаргаж ирсэн энэ 363 тэрбум төгрөгөө, хөрөнгө оруулалтын ажлаа, хүний хөрөнгөө бүгд эргүүлж тат. Энэ ахмадуудаасаа харамлаж байсан энэ 8.6-хан хувийн өсөлтийг 15, 20 хувьд хүргэх төсвийг нэм. Тэр 15 хувийн нэмэх гээд байгаа эмч нарын төсвийг 25 хувиар нэм. Ингээд бүгдээрээ төсвөө ирэх долоо хоногт багтаагаад баталчихъя. Энэ өөр ямар ч арга байхгүй. Тийм учраас та нар маань ичихгүй бол энэ хөрөнгө оруулалтын ажлуудаа бүгдээрээ татчихаач. Би та нараас гуйж байна. Энийгээ ахмадууддаа өгчих, эмч нартаа өгчих. Бүгдээрээ наанаа болохоор юм яриад бүгдээрээ энд хонины арьс нөмөрсөн чононууд сууж байгаа юм. Зурагт телевизийн өмнө харахаараа гоё ярьж цалин нэмүүл гэххээд цаагуураа болохоор ард түмэнд очих мөнгийг өөрсдөө хулгайлж сууж байгаа. Энийгээ боль.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ер нь би нэг зүйлийг хэлэхэд энд сууж байгаа Ардчилсан намын гишүүд бүгдээрээ бүгдээрээ Засгийн газрыг огцруулах ийм кноп дарсан. Энэ чинь одоо огцруулсан хүн нь яагаад буруу болчихдог юм бэ гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт нь манай Сандаг-Очир дарга, хөөе Сандаг-Очир гишүүн болохлоор Засгийн газар дээрээ хөрөнгө оруулалтаа бүгдийг нь тавьчихаад ороод ирдэг юм. Өөрөөр хэлбэл Налайх дулааны шинэ эх үүсвэр 79мвт-ийн эхний ээлжийн ажил гээд 55 тэрбум төгрөгөөр, дээрээс нь Багануур тойргийн авто зам 14.4км Багануур хот гээд 43 тэрбум гээд ингээд нийтдээ нийтдээ 100 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тавьчихсан байгаа. Тэгээд энэ хөөх, тэгээд би бол тоо ярьдаг хүн шүү. Төсөв дээрээ, Төсвийн төсөл дээрээ өргөн барьсан төсөл дээр хэлж байгаа шүү. Би ер нь худлаа тоо хэлдэггүй.

Отгоны Саранчулуун асуулт асууя.

О.Саранчулуун: Оройн мэнд. Монголд ер нь хавдраар өвдөөгүй, хамаатангүй эсвэл тийм айл ер нь бараг байхгүй л байх даа. Хүн болгонд л тийм асуудалтай. Тэгээд хавдраар 1 хүн нас бардаг. Тэндээс амьд үлдсэн хүмүүс нь болохоор асаргаанд орчхоод байгаа. Асаргааны тэтгэмжийн асуудлыг Баясгалан гишүүн санаачлаад зөндөө гишүүд гарын үсэг зураад бид нар баахан ярьсан шүү дээ. Тэгээд энэ асуудал ер нь яахаар болж байна вэ гэдгээс хариулт авъя. Хэн асаргаанд орж байна гэхлээр өвдсөн, үйлдвэрлэлийн ослын гэмтэл, авто осол, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй төрсөн, хүнд өвдсөн хүмүүс өнөөдөр асаргаанд ороод явж байгаа. Тэгээд энэ мөнгө үнэхээр амьдралд нь хүрэхгүй байна гэж байгаа юм. Тэгээд энэ дээр ер нь манай улс яах юм бэ? Цаашдаа ер нь ямар дүнг иргэдэд хэлэх вэ гэдгийг асууя.

2 хоногийн дараа аягүй цочир хүйтэрнэ гээд тэгсэн. Тэгээд иргэд хүйтрэхээр гадаа тэргэнцэртэй хүмүүс бас талбай дээр сууж байна. Тэгээд хүн нас барчихвал яах билээ гэдэг асуудал байна. Гадаа тэргэнцэртэй хүмүүс сууж байгаа. Тэргэнцэртэй хүмүүсийн хэрэглэдэг, босож явж бие засаж чаддаггүй учраас хэрэглэж байгаа зүйлүүд нь хүйтэнд бас их хэцүү байдаг. Тэгэхээр энэ асуудал дээр, Батсуурь гишүүн ээ би ярьж байна шүү дээ энд. Та ямар юу юм бэ бид нар энд юм яриад байна шүү дээ. Хүн яриад байхад чинь сонсчих л доо. Би таныг түрүүн ярихад чинь сонсоод сууж байсан шүү дээ. Тэгэхээр гадаа хүмүүс зогсож байна. Тэгэхээр энэ ийгмийн халамжийн сангаас өгч байгаа төсөв дээр ялангуяа энэ хамгийн эмзэг байгаа сэхээнд байгаа хүмүүсийн асуудал дээр ямар шийдвэр гаргах юм бэ? Тэр 300 мянгыг нь 500 ч юм уу болгоод нэмчих асуудал арга байна уу гэдгийг би хариулт хүсмээр байгаа юм.

Дараагийнх нь төв болохоор. Би асрамж, халамжийн асуудал ярьж байна шүү дээ. Та ямар бүдүүлэг юм бэ? Дандаа идэж ууж байх юм ярьж байна гэж юу гэсэн үг юм. Өвдсөн хүмүүсийн асуудал ярьж байна. Таны гэр бүл бүгдээрээ эрүүл юм уу бүүр инээж минээгээд тавлаад байх чинь харин юу вэ сонсоод суугаад байхад чинь. Дараагийн асуудал нь Өнөр бүл төвийн төсөв хасагдсан байна лээ. Өнөр бүл төв яах юм, хэзээ ашиглалтад орох вэ? Баригдах нь яаж ер нь ашиглалтад орох юм? Яагаад гэвэл одоо маш олон хүүхдүүд нөгөө очих газаргүй байгаад байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс. Хөгжлийн бэрхшээлтэй ч гэсэн энэ улсын иргэн шүү дээ ер нь бол. Ингэж хүн юм ярьж байхад тавлахаа болимоор байна. Тэгэхээр энэ Өнөр бүл төвийн асуудлыг хариултыг авмаар байна.

Дараа нь аж ахуй нэгжийн орлогын 1 хувийн татвар гээд бид нар нөгөө өнгөрсөн жил шинэ хуулийн заалтаар ийм юу гарсан байгаа. Энэ дээр өөрчлөлт байгаа юу энд ер нь хэчнээн төгрөг орж ирээд хаашаа зарцуулагдах вэ гэдэг ийм тооцооллыг бас сонсьё. Ийм 3 асуулт байна.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Ер нь Саранчулуун гишүүн бас зөв асуудал хөндөөд байгаа шүү. Та бүхэн заавал хариулах ёстой. Хэлэлцэх асуудалтай холбоогүй гэж байж болохгүй. Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Саранчулуун гишүүний зарим асуултад хариулъя. Асаргааны тэтгэмж 25 онд 76.8 мянган хүн, нийтдээ 186.3 тэрбум төгрөгийн төсөв 25 онд тавигдсан байсан. 2026 оны төсвийн төсөлд 2 дахин нэмэгдүүлээд 320.2 тэрбум төгрөг төсөвлөсөн байж байгаа. Асаргааны тэтгэмж дээр. Баясгалан гишүүний

гаргаж байгаа санал бол асаргааны тэтгэмжийг нэмэгдүүлэх ийм саналууд гаргаж байгаа. Энийг мэдээжийн хэрэг улсын төсөвт нэмэгдүүлэх үү гэдгийг Улсын Их Хурал шийдэх ёстой.

Ерөнхийдөө халамж руу чиглэсэн зардлуудыг ерөөсөө огт бууруулаагүй. 26 оны улсын төсөв дээр бид нар байнга нэмэгдүүлж өгч байгаа. Саранчулуун гишүүний бас санаа зовоод явдаг хараагүйчүүдийн үйлдвэрийн хөрөнгө оруулалтын асуудлыг яамныхаа буюу сайдын захиран зарцуулах хөрөнгө дотроос зохицуулалт хийх бололцоотой явж байгаа. Тэгээд хараагүйчүүдийн үйлдвэр маш олон бүтээгдэхүүнийг нийлүүлдэг бас тоног төхөөрөмжөө шинэчилчихсэн ийм сайн үйлдвэр байгаа учраас дараа жилийн улсын төсөв дотор та бүхэн сайн мэдэж байгаа энэ цалин, тэтгэвэр нэмэхтэй холбоотой ихэнх шинэ хөрөнгө оруулалтууд татагдсан байж байгаа. Гэхдээ үйлдвэрийг тасалдахгүй явуулах хүрээнд яам арга хэмжээ авна гэж хариулъя.

Б.Пүрэвдорж: Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: 26 оны.

Б.Пүрэвдорж: Уучлаарай түр зуур хүлээж байгаарай. Саранчулуун гишүүн нэмж тодруулъя.

О.Саранчулуун: Нэг нь аж ахуйн нэгжийн орлогын хувь нь татвараас хөнгөлөлтөөс орж ирэх хувь тооцоолол ямаршуу дүн байна, тэгээд үүгээр яг юу зарцуулахаар яригдаж байгаа асуудал байгаа. Тэгээд өнөр бүлээ хэзээ ашиглалтад оруулах вэ гэдэг асуудал байгаа. Өнөр бүл.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Тэр нийт орлогынхоо 1 хувьтай тэнцэх татварын хөнгөлөлтийг хуульд заасан зориулалтаар зарцуулбал энэ хөнгөлөлтийг эдэлж болно оо гээд ийм зохицуулалттай. Энэ бол саяын нөгөө Саранчулуун гишүүний ярьж байгаа шиг хүмүүс бас буруу ойлгоод байх шиг байгаа юм. Тийм орлого орж ирээд тэрийг нь төр зарцуулах юм шиг ийм ойлголт яваад байгаа юм. Энэ тийм биш шүү. Энийг юунд зарцуулахыгаа тэр төсөвт, хууль дээр юунд зарцуулбал гэдэг хүрээг нь заачихсан байгаа. Татвар төлөгч өөрөө сонголт хийгээд хүсвэл тухайн төсөл нь тэр хүрээндээ байх юм бол тэрэндээ зарцуулж болдог. Өөрөөр хэлбэл татвар төлөгчийн өөрийнх нь сонголт, эрх мэдлийн асуудал. Энийг бид төрөөс захиргааны шинжтэй ч гэдэг юм уу чиглүүлээд л тийш нь өг, энийг хийе эд нар.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Тооцооллыг Татварын Ерөнхий газрын даргын үүрэг гүйцэтгэгч. Индэрийн 4 дүгээр микрофон. Эхлээд Аубакир сайд хариулж байя.

Т.Аубакир: Өнөр бүл дээр 2026 онд 8.4 тэрбум төгрөгийн санхүүжилт байсан. Ингээд сая нөгөө төсөв хасахтай холбоотой 1.2 тэрбум төгрөгийг 15 хувиар бууруулаад ингээд 27 оноор дамжихаар үйл ажиллагаа нь тасалдахгүй явж байгаа. 8.4-ийн санхүүжилт авах байсан бол 1.2 буураад л орж ирсэн гэсэн үг. Бүх сайд нарын төсвөөс үндсэндээ 15-50 хувь хүртэл бууруулсан шүү дээ. Шинэ

хөрөнгө оруулалтууд энэ тэр. Үүнд нь 1.2 тэрбум төгрөг хасагдаж байгаа. Өнөр бүлийн ажил бол зогсохгүй цааш цааш үргэлжилнэ.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон.

С.Төгсжаргал: Татварын ерөнхий газар Төгсжаргал. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дээр хөнгөлөлтийн асуудал байгаа. Энэ хууль маань өнгөрсөн оноос эхлээд хэрэгжээд явж байгаа. Өнгөрсөн 2024 оны жилийн эцсийн аж ахуйн нэгж байгууллагууд энэ орлогын татварын тайлангаар нийтдээ 87 аж ахуйн нэгж байгууллага маань 44.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг эдлэхээр ийм тооцоолол урьдчилсан байдлаар гарчихсан ингээд явж байгаа. Татварын алба үүнийгээ хянан баталгаажуулах ажлыг хийж явна. Түрүүн Жавхлан сайдын хэлснээр аж ахуйн нэгж байгууллагууд маань тухайн салбар, хөрөнгө оруулалт санхүүжилтийн асуудлаа өөрсдөө сонголтоо хийгээд хөрөнгө оруулалт буюу санхүүгийн дэмжлэгүүдээ ингээд гаргаад явах юм. Бидний зүгээс тухайн яамдаас, харьяа тэр салбарын яамдаас баталсан стандарт шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалт

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя. Болчихсон юм уу?

С.Төгсжаргал: Яамдын тавьсан гаргасан, баталсан стандарт шаардлагуудын хүрээнд тухайн хөрөнгө оруулалт, санхүүжилт нийцсэн байх юм бол хөнгөлөлтийг эдлүүлэх зарчмаар ингээд хэрэгжүүлээд явна. 2025 оны хувьд орлогын татварын тайлан маань өссөн дүнгээр буюу 26 оны 2 сарын 10-нд эцэслэн тайлан нь гарна. Тэр үед аль байгууллага аль салбарт хэчнээн аж ахуйн нэгж хөрөнгө оруулалт, дэмжлэг үзүүлэх энэ тооцоолол нь эцэслэн гаргах байгаа. Тэгэхээр одоогоор 25 оны тооцоо мэдээлэл хараахан гараагүй байгаа.

Б.Пүрэвдорж: Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: 26 оны төсвийн тухай хуулийг дагаж орж ирж байгаа энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн өөр нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа. Энэ өөрчлөлт хийгдээд ирэх жил бас хувийн хэвшилд жоохон орон зай гарах байх, бас төрийн энэ ачаанаас үүрэлцэх байх, бас орон нутагт шинэ бүтээн байгуулалтууд эхлэх байх гэж ингэж найдаж байна. Тэгээд энэ Түншлэлийн хуулийг зассанаар, өөрчилснөөр бас бүх асуудал шийдэгдчихгүй л дээ. Жишээлбэл, энэ орон нутагт бүтээн байгуулалт хийе, шинэ хөрөнгө оруулалт хийгээд юм барья гэхээр газрын асуудал үүсдэг болчихсон. Газрын тухай хуульд ер нь өөрчлөлт оруулах уу? Ер нь энэ Эдийн засаг, хөгжлийн яам энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуультайгаа уялдуулаад өөр Газрын тухай хууль ч юм уу, Татварын тухай хууль ч юм уу ер нь ямар өөрчлөлтүүдийг ингэж цогцоор нь хийх вэ энэ дээр хийсэн судалгаа байна уу? Тэгэхгүй бол зөвхөн энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд хэдэн зүйл, заалт, өөрчлөлт оруулснаар бас ажил урагшилна гэж ингэж харахгүй байна л даа.

Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт хэлээч. Өөр ер нь ямар ямар хуулийн өөрчлөлтүүд хийх вэ гэж? Жишээлбэл орон нутагт ингээд Өвөрхангай аймагт жишээ нь орон сууцын бүтээн байгуулалт хийе гэхээр газрын асуудал дээр очоод гацчихсан. Дахиад тээвэр ложистикийн төв барья гэхээр дахиад л газрын асуудал дээр очоод гацчихсан. Яагаад вэ гэхээр одоо Газрын тухай хуулиар заавал

дуудлага худалдаа юм уу ийм сонгон шалгаруулалт явж байж газар олгоно, газрыг ашиглана гээд ингээд орчихсон. Тийм учраас энэ Газрын тухай хуульдаа ер нь өөрчлөлт оруулах юм уу? Энэ тал дээр тодорхой хариулт хэлээд Эдийн засаг, хөгжлийн яам өөр ямар хуулийн өөрчлөлт хийж байж энэ яг төр хувийн хэвшлийн түншлэл маань амь орж, энэ хувийн хэвшилд ээлтэй ийм хууль болох вэ гэдэг дээр хариулт өгмөөр байна.

Дараагийнх нь энэ бас дагаж орж ирж байгаа энэ нүүрсний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор 1 тэрбумын үнийн дүнтэй 3-5 удаагийн арилжаа зохион байгуулж мөнгө оруулж ирнэ гээд ингээд заачихсан байгаа. Энэнтэй холбоотойгоор ер нь энэ нүүрс, тээврийн бизнес маань юу болж байна? Нүүрс тээврийн салбарынхан Зам, тээврийн сайдаас асууж байгаа нүүрс тээврийн компаниуд маань маш хүнд байдалтай байгаа, дампуурч байгаа. Тэгээд явж байгаа боловч ашиггүй ажиллаж байна, бөөн хүнд суртал проблем тэгээд л эндээс очиж байгаа түлшний компани, тээврийнхэн нь хүртэл өндөр татвар хураамж төлдөг болчихлоо. 1 машинаас 150 мянган төгрөгийн замын хураамж авч байна гэх зэргээр ингээд олон асуудлууд байна. Энийг ер нь яаж бас хөнгөвчлөх вэ? Энэ чинь гол мөнгө олж байгаа нүүрс, тээврийн салбар дээрээ ийм олон бөглөөс хийгээд, ингээд боомилоод, шинэ журам гаргаад, замын төлбөрийг нь хүртэл нэмээд байхаар чинь ер нь бид нар нөгөө талдаа энэ хувийн хэвшлээ ер нь дэмжиж байгаа юм байна уу, хувийн хэвшлээ улам боомилоод байгаа юм биш үү гэж ингэж харж байна.

Дараа нь энэ орон нутагт хийж байгаа бүтээн байгуулалтыг манай бас энэ зарим гишүүд эсэргүүцээд байх шиг байна. Тэр орон нутагт очиж ажиллаж, амьдарч үзмээр байна л даа. Тэнд чинь өчнөөн олон хүн амьдарч байна. Тэр нутгийн иргэдэд зам хэрэгтэй байна. Цалин, тэтгэвэр нэмэх нь зөв. Гэхдээ багшид хэчнээн өндөр цалин өгчхөөд нурж унах гэж байгаа сургуульд ч юм уу тав тухгүй орчинд хичээл заа гэвэл яаж тэр багшийн нийгмийн баталгааг хангаж ажиллах орчныг нь бүрдүүлж өгөх юм бэ? Тэгэхээр тэр хөдөө орон нутагт сургуулиа баримаар байна, засвараа хиймээр байна, замаа ч хиймээр байна. Ингээд бүх юмаа цогцоор нь авч үзмээр байна. Тэгэхгүй л хэтэрхий попроод цалин нэмбэл сайн, бүүр сүүлдээ бүтээн байгуулалт ярьж байгаа бүтээн байгуулалт хийх гэж байгаа гишүүд нь муухай болж харагдах гээд хулгайч бараг нэр зүүж байх шиг байна л даа. Тэгэхээр ийм зүйл байхгүй. Тийм учраас энэ дээрээ бас бүтээн байгуулалт орон нутагт хиймээр байна гэдэг ийм саналтай байна.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Ер нь ингээд төлөвлөлт муу явж ирснээс болж өнөөдрийн урсгал зардлын энэ замбараагүй өсөлт бий болсон. Тэгээд энийг засахын тулд энэ урт хугацааны бодлого, дунд хугацааны бодлого, энэ таван жилийн үндсэн чиглэл, таван жилийн үндсэн чиглэлд суурилсан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тухайн жилийн төсөв нийцэж байгаа эсэх гээд энэ асуудлыг илүү системтэй болгох гэж хөгжлийн бодлоготойгоо уялдуулах гэж л энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль анх гарсан.

Тийм ч учраас улсын жилийн төлөвлөгөөнд 126 төсөл бичигдчихээд байхад улсын төсвөөр 76-хан төслийг нь санхүүжүүлэх бололцоо байна. Бусад төсөл нь санхүүжих ямар ч механизм гарц байхгүй. Тэгэхээр яаж улсын жилийн

төлөвлөгөөнд энэ ирэх жилийн төсөв нийцсэн бэ гэдэг нийцсэн гэж дүгнэлт өгөх юм бэ. Дүгнэлтийг нь Эдийн засаг, хөгжлийн яам өгөх гээд байдаг. Тэгэхээр үүнийг шийдэхийн тулд зайлшгүй шинэ, арга механизмыг эрэлхийлэх ёстой. Тэр нь төр, хувийн хэвшлийн түншлэл.

Гэтэл төр, хувийн хэвшлийн түншлэлийн одоогийн хэрэгжиж байгаа хууль яг энэ үе шатуудыг нь дамжаад 3 удаа тэр зөвшөөрөл аваад, яамных нь тэр жагсаалтад ороод, Засгаар ороод тэгээд урьдчилсан үнэлгээ тэр бүрэн шинжилгээг нь хийгдээд хамгийн сүүлд нээлттэй сонгон шалгаруулалт хийгдээд хамгийн бага үнийн дүн өгсөнд нь өгчихдөг. Тэгээд нөгөө гаднын түншлэлээр орж ирэх гэж байгаа хөрөнгө оруулалт хийх гэж байгаа компанийн нөү хау-г нь ашиглаад л ингээд л газар хэрэггүй мэтээр хаячихдаг. Ийм л байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг нь шийдэхийн тулд аймаг орон нутаг өөрөө бие даагаад түншлэлийн төслөө хэрэгжүүл. Өмнө нь түншлэлийн төслийн, түншлэлийн хуулиар энэ нийслэл улсын төсвөөс татаас авдаггүй аймгууд хялбаршуулсан журмаар шийддэг болгосон.

Тэгэхээр энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль өөрөө аймаг, орон нутагт нь энэ эрх мэдлийг нь өгснөөрөө газрын асуудал давхар шийдэгдэх бололцоо бүрдэнэ. Уг нь түншлэлийн хууль дээр тэр зөвшөөрөл өгөх, тэр газар олгох, ажиллах нөхцөл бололцоогоор хангах гээд Түншлэлийн хуулиар зохицуулж өгсөн хэдий ч төрийн захиргааны төв байгууллага өөрөө түншлэлийнхээ төслийг хэрэгжүүлбэ гээд жагсаалтдаа оруулаад, тэр бүрэн шинжилгээг нь хийгээд урьдчилсан шинжилгээг нь хийлгээд явуулж байтал нөгөө аймагт нь газар олгооо гээд төрийн захиргааны төв байгууллагаас нь үүрэг өгөөд байхаар энэ ажлыг нь явуулдаггүй. Ингээд аймаг өөрөө хэрвээ тэр түншлэлийн төслөө өөрсдөө хэрэгжүүлээд нутгийн өөрөө удирдах байгууллагаараа оруулаад ингээд шийдээд явбал нэг ёсондоо тэр төслийн бүрэн байдлыг нь хангах, бэлэн байдлыг нь хангах эрх, үүрэг нь өөрөө аймагт нь ирнэ.

Тэгэхээр аймаг өөрөө газрыг нь олох асуудлыг өөрөө шийдвэрлэнэ гэсэн үг. Нэг ёсондоо хөрсөндөө буусан амьдралтай түншлэлийн төслүүд хэрэгжүүлээд эхэлнэ л гэж ойлгож байгаа. Тэгэхээр хуульд нь хүртэл хатуу заачихсан байгаа газар олгох, зөвшөөрөл өгөх бүх талаар дэм.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмж Дэлгэрсайхан сайд тодруулж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Би таны хэлж байгаатай бас санал нэг байна. Тэгэхдээ та бас бид ер нь энэ дэд бүтэц хөгжөөгүй улс шүү дээ. Ер нь бодит байдал дээр. Хэдэн тийшээ жоохон бага даацын зам тавьсан. Тэгээд одоо та энэ 150 мянган төгрөгийн төлбөр аваад байна гэж ярьж байх шиг байна. Ер нь бид ялангуяа энэ уул уурхайн бүтээгдэхүүн ачсан машинуудыг нийтийн хэрэглээний хатуу хучилттай авто замаар явахдаа 150 мянган төгрөгийн төлбөр авахыг Засгийн газрын 25 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 77 дугаар тогтоолоор энийг шийдсэн. Энийг шийдэхгүй бол ингээд нэгдүгээрт замаа засах мөнгө байхгүй бид. Хоёрдугаарт та өөрөө мэдэж байгаа.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя. Нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Тэгээд даац хэтрүүлэхгүй байх үүднээс энэ хяналтыг тавьж байгаа. Нөгөө талаараа уул уурхайн бүтээгдэхүүний бас экспортыг дэмжих зорилгоор энэ тогтоол гарсан. Энэ журмыг гаргаснаараа өнөөдөр ямар нэгэн жолооч нараас ямар нэгэн гомдол ирээгүй, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ ганц нүүрс биш жонш, төмрийн хүдэр гээд бүх төрлийн уул уурхайн бүтээгдэхүүнд зориулж тавигдсан ийм татвар байгаа юм. Энэ урьд нь вагоноор зэрэг явж байгаа. Тэгэхдээ бид бас ингээд Улаанбаатар хотыг дулаанаар хангахын тулд Улаанбаатар төмөр замд байгаа 1 мянга, уул нь ДЦС-уудын нүүрсийг ойролцоогоор 1200 вагоноор хангадаг. Гэтэл өнөөдөр бид яг бодит байдал дээр 800 вагонтой тэгээд хувийн хэвшлээс вагонуудыг нь татаж авч байж нүүрсээ, дотоодын нүүрсээ, энийгээ хангаж байна. Энэ.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: Дэлгэрсайхан сайд жолооч нараас санал, гомдол ирээгүй гэж хариулж байх юм. Энэ чинь хэдхэн хоногийн өмнө бүгдээрээ л харсан даа энэ ордны баруун хаалган дээр баахан тээвэрчид ирчихсэн зогсоод л бид нартай хүртэл уулзсан шүү дээ. Дээр нь дахиад энэ урагшаа явж байгаа Төв аймгийн наад талын пост дээр постын хажуу талд 20, 30.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Дэлгэрсайхан сайд хариулъя. Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Хосбаяр гишүүн ээ энэ ордны гадаа ирсэн чинь манай шатахууныхан ирсэн юм. Та мэдэж байгаа шатахуун хоорондоо ингээд зарим нь их хэмжээтэй ачна 50, 60 тонноор явна гээд байдаг, зарим нь даацаараа явна гээд хоорондоо маргаад энэнээс болоод энэ ордны гадаа ирж жагсаад байгаа юм. Ер нь уул уурхайн бүтээгдэхүүнийг нэг талаараа ингээд дэмжиж байгаа.

Нөгөө талаараа бид цаашдаа төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн ач холбогдолтой үр өгөөжтэй зам тавьж байж энэ 100 тонны, 200 тонны даацтай энэ явж байж л бид нар цаашдаа энэ зам чинь хөгжинө өө. Үнэгүй замаар явсаар, төсвийн мөнгөөр зам тавьсаар байтал бид нар үндсэндээ ний нуугүй хэлэхэд төсөв сүүлдээ даахаа байсан. Тавьсан замаа битгий хэл, өнөөдөр шинээр зам тавих нь битгий хэл тавьсан замынхаа засварыг хийж чадахгүй ийм байдалд хүрчхээд байгаа юм. Бид нар ойролцоогоор 8000 гаруй хатуу хучилттай зам байна.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураах ёстой. 15 санал байгаа. Үг байхгүй.

Монгол Ардын намын бүлгийн ирц хангалтгүй байгаа тул санал хураалтыг маргааш өглөө явуулахаар хойшлуулъя.

17.45 цаг

Дараагийн асуудалд оръё. Хэлэлцэх асуудал хоёр. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025 оны 10 сарын 6-ны өдөр өргөн мэдүүлсэн үргэлжилнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг 2025 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн 14 цаг хүртэл завсарлага авсан. Мөн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн хүсэлтээр завсарлагын хугацааг 2025 оны 11 сарын 6-ны өдрийн 15:30 хүртэл сунгасан бөгөөд завсарлагын хугацаа дууссан байна.

Бүлгийн дарга, Монгол Ардын намын бүлгийн дарга алга байна. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай танилцуулна. Индэрт урьж байна.

М.Мандхай: “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, 2025 оны 11 дүгээр сарын 5.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүнээс 2025 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус Байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь Тавантолгойн бүлэг ордод хамаарах Эн Ви 011952 дугаартай Ухаа худаг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайг эзэмшигч, хуулийн этгээдийн оруулсан хөрөнгө оруулалт, олборлосон нүүрс, үйл ажиллагаа, мөнгөн урсгалд дүн шинжилгээ хийх, Тавантолгойн бүлэг ордоос олборлосон нүүрстэй холбогдуулж байгуулсан оффтейк гэрээнүүд холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийж, иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Хянан шалгах түр хороо байгуулах тухай тогтоолын төсөлд тусгагдсан хүрээ хязгаар нь Аудитын байгууллагаас 2012 онд хийгдэж байсан сэдэвтэй болон Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн үйл ажиллагаатай давхардаж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” тогтоолын төслийн сэдэв, хүрээ хязгаарын бусад тусгай зөвшөөрөлтэй талбай гэсэн нь хэт ерөнхий байгааг тодорхой болгох, ийм хэт ерөнхий өргөн хүрээтэй байгаа нь Тавантолгой бүлэг ордын нүүрс олборлох, борлуулах, бусад үйл ажиллагааны талаар өөр Хянан шалгах түр хороо байгуулах тохиолдолд хэрхэн зохицуулах талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг баримтлан тогтоолын төслийн сэдэв, хүрээ, хязгаар Монгол Улсын Үндсэн хуульд харшилсан

эсэх талаар санал хураалт явуулах үед хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72.2 хувь нь Хянан шалгах тухай, түр хороо байгуулах тухай тогтоолын төслийн тусгай шалгалтын сэдэв, хүрээ, хязгаар нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн гэж үзэж тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж.

Б.Пүрэвдорж: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Батсуурь гишүүнээр тасаллаа.

Одоо 17 цаг 57 минут болж байна. Тийм учраас энэ асуудлыг маргааш Монгол Ардын намын бүлгийн ирц сайжирсан үеэр санал хураалтыг явуулах бас зайлшгүй шаардлага байна. Тийм учраас дээрээс нь Байнгын хорооны дүгнэлттэй холбогдуулан Сэддорж дарга бас хариулах ёстой. Оюун-Эрдэнэ гишүүн бас хариулах ёстой. Тийм учраас өнөөдрийн чуулганы хуралдааныг, энэ асуудлыг маргаашид шилжүүлж, өнөөдрийн чуулганы хуралдааныг хааж байна.

17.50 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

